



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ



Нэг. ХӨМРӨГ ҮҮСГЭГЧИЙН ТҮҮХ...

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрийн түүхэн эх сурвалжаас:

Тус дүүрэг нь зүүн өмнө талаараа Сүхбаатар дүүрэг, баруун талаараа дөрвөн замын бэлчирээс зүүн тийш Гандангийн дэнжийн ёроолоор Гэсэр сүмийн өмнөх дөрвөн замын бэлчирт хүрч тэндээсээ төв телевизийн зүүн замаар Мааньт хөтөл хүртэлх газраар Баянгол, түүнээс хойш Чингэлтэй уулын усны хагалбараар Сонгинохайрхан дүүргүүдтэй тус тус хиллэн оршдог.

Тус дүүргийн нутаг дэвсгэрт Баруун сэлбэ голын дунд хэсэг, Ногоон нуур болон хэд хэдэн булаг шанд байдаг. 1778 онд Их хүрээг Хүй мандлаас ирж Сэлбийн хүн чулууны хойд талд буусан үеэс эдүгээгийн Чингэлтэй дүүргийн нутагт хүрээний зарим аймаг, дацангийн эсгий гэр буюу модон дуган сүмүүд барьж хүн суурьших болжээ. XIX зууны сүүл XX зууны эхэн үеийн хүрээний зургуудаас үзэхэд зүүн хүрээний цогчин дуганаас баруун урагш эдүгээгийн 5 дугаар дунд сургуулийн зүүн өмнө Зурхай, түүний урд талд « Дуу үл тасрах хурал » зэрэг гурван хурлын газар байсны зүүн талынх нь Түвд модон барын хэвлэлийн газар байжээ.

Мөн түүнчлэн зүүн хүрээ 30 аймгаас Дондилиин, Жадар, Тойслун, Дуйнхар, Сэцэн тойн, Андуу нар, Дашдандарлин, Маха-маяа, Жас хэмээх 9 аймгийн дуган сүм, лам нарын хашаа энэ дүүргийн нутагт хамаарах газар байсан байна. Эдгээрээс Жадар,Тонслун аймгууд болон Жүд дацангийн тариалангийн газар эдүгээгийн Төв аймгийн дунд урт, Баруун угтаал, Хоолтод байжээ.

Зүүн хүрээний энэ хэсэгт Сэцэн тойны аймгийн өргөн чөлөөний зүүнээсээ тавдахь хашаанд буюу эдүгээгийн орон сууцны 41 дүгээр байрны орчимд хувьсгалын долоогийн нэг ардын түр засгийн газрын анхны ерөнхий сайд, сүүлд богдын шадар сайдад ч дэвшиж явсан Чагдаржав, Дуйнхарын аймгийн лам мөн шадар сайд да лам Пунцагдорж зэрэг монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтнүүд суудаг байжээ.

Их хүрээг 1855 онд Толгойтоос нүүж ирсний дараахан 1858 онд хүрээнээс хойш 10 км зайд Сэлбэ голын баруун гараас орсон Чингэлтэй уулын нэгэн аманд Шадублингийн ам хэмээх хийд байгуулснаар энэ амыг «Шадублингийн ам» хэмээн нэрлэх болжээ. Тус хийд нь Зүүн хүрээндээ шууд захирагддаг, байсан Түүхчилсэн лавлах

хийгээд лам нар даяан хийж ном бясалгахдаа тэнд очиж тодорхой хугацаагаар суудаг, даяанч лам нарын хийд байсны дээр богд хааны зарлигаар монголын нууц тагнуулын газрын ажилтнуудыг энд бэлтгэдэг байсан мэдээ бий.

Чингэлтэй дүүргийн баруун өмнө зах буюу хотын баруун дөрвөн замын бэлчир хавь нь хуучин Их хүрээний баруун өмнөд хороонд байсан «Бадарчны дов» хавиас эхэлж байв. Энэ дов дээр Дотоод явдлын яамны ажилтнуудад зориулсан тусгай халуун усны газрын барилга барьжээ. Түүнийг хожим хими цэвэрлэгээ угаалгын комбинат болгожээ.

Бадарчны довын хойд хэсгээс Засагт хан аймгийн харъяат задгайд суудаг айлууд болон Түвдийн хороо уруу нэвтэрдэг Баруун сэлбэ голын нэгэн гүүрийг Зодоч нарын гүүр гэх бөгөөд энэ гүүрний баруун этгээдэд Тан-танжалбу буюу зод лүйжингийн хурлын дуган байв. Энэ дуганы орчимд ардын засгаас хойш Буриадын хороо бүрэлджээ. Тус хороо Гандангийн дэнжийн зүүн урд ёроолд хүрсэн олон айл бүхий том хороо байсны дээр тус хорооны дэвсгэрт бүр 1921 оноос өмнө монголд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн Герман улсын «Востбанк» хэмээгч худалдааны пүүсийн нэгэн салбар агуулахууд байсан байна. Хожим түүний суурин дээр Мебелийн фабрик байгуулсан нь эдүгээ ч хөгжсөөр буй болой.

Бадарчны довын хойт «Арк» хэлбэртэй том суварга байсан бөгөөд түүнийг шургадаг суврага гэнэ. Ийм суврага эдүгээгийн Чингэлтэй дүүргийн нутагт хоёр байсны нэг нь «Туул» зоогийн газрын хавьд байв. Бадарчны довын хойдох шургадаг сувраган доогуур бадарчингууд харийн нутагт бадарчлан одох юмуу хариас орон гэртээ буцаж ирэхдээ шургадаг байжээ. Энэ нь хүний нутагт өвчин зовлон, хов жив, хэрүүл маргааны зүйл дамжуулахгүй, хариас эх нутаг, гэр орондоо элдэв муу зүйл ирүүлэхгүй хэрэв биед тийм зүйл буй бол ариутгах гэж үйлддэг зан үйл байсан гэдэг. Харин нэг сувраган доогуур нь нядлах малыг алахын өмнө шургуулж сүнсийг нь зайлуулдаг байжээ.

Буриадын хорооны зүүн залгаанд Баруун сэлбэ голын зүүн талын тохойд Түвдийн хороо хэмээх хэдэн гудамж айл байв. Энэ хороог 1904 онд ХШ далай лам Түвдэнжамцыг монголд ирэхэд түүнд өргөсөн өргөл барьцны зүйлээс бүрэлдэж

эхэлсэн сан хөмрөгийг «Далай ламын сан» хэмээн нэрлэж түүнийг толгойлсон «Шанзав түвдийн газар» гэгч буй болсны дараа бүрэлдэн үүссэн гэдэг юм. Энэхүү далай ламын сан, шанзав түвдийн газар нь Түшээт хан аймгийн Түшээт вангийн хороо, Сайн ноён ханы хорооны заагт байв. Шанзав түвдийн газраас баруун тийш, Сайн ноён ханы хорооны хойд тал. хүрээний их зээл буюу шинэ захаас урагш, өөрөөр хэлбэл эдүгээгийн Энх тайвны өргөн чөлөөнөөс хойш Худалдааны гудамжаас урагших хэсэгт хятад, орос, монгол худалдаа, үйлчилгээний олон газар байв. Үүнээс заримыг дурдахад; Шинэ захын урдхантай байсан Сулейманов гэгч татар худалдаачны хувийн клуб байв. Тус клубт ширээний бөмбөг тоглодог байсны учир хүрээнийхэн түүнийг «Бөмбөгний байшин» гэж нэрлэх нь их байжээ. Ший жүжиг тоглож, бүжиг наадам болдог, шөнийн цэнгээний газар бүхий энэхүү клубын үйлчилгээг 1922 онд зогсоож байшинд нь Монгол улсын Дотоодыг хамгаалах газар байрлах болсон байдаг Дотоодыг хамгаалах газар эндээ 1934 он хүртэл байрлаж байгаад гарснаас хойш энд Цагдан сэргийлэх, Улсын номын худалдааны газар, Дотоод явдлын яамны намын хороо байрлах болжээ. Хотыг шинэчлэн байгуулах явцад хуучин Сулеймановын клубын хоёр давхар модон барилгыг буулгаж, хожим тэр хавьд мөн хоёр давхар тоосгон байшин барьж нийтийн ахуй үйлчилгээний комбинатын контор болгосон нь эдүгээ худалдааны гудамжинд байдаг.

Сулеймановын клубээс зүүхэнтэй хятад эзэнтэй халуун усны газар түүний зүүн талд эдүгээгийн «Туул» зоогийн газрын баруун өмнө этгээдэд Англи улсын «Бедерман» хэмээх их пүүсний нэгэн дэлгүүр байв. Тэнд гол төлөв төрөл бүрийн гутал худалддаг байсан гэдэг. Энэхүү Англи дэлгүүрийн дэргэд «Бүжид хүүхний халуун ус» нэртэй хувийн монгол халуун усны газар байсан бөгөөд тэрээр ардын засгаас хойш улсад татвар төлж, зарим зүйлээ хотын захиргаанаас аваад нийтэд үйлчилсээр байсан манай анхны нийтийн халуун усны газар байжээ.

Нийтийн ахуй үйлчилгээний удирдах газрын хоёр давхар байшингаас зүүн урагш эдүгээгийн Баруун сэлбийн гудамж буюу хуучин усны гудамжны баруун салааны эхэнд Америк улсын есөн хуруут Ланчансан хэмээхийн их пүүсийн салбар байв. Энэ пүүс монголоос морь худалдан авч хятадын Шанхай хотод байдаг зүүн

Азийн боомтод хүргэж тэндээс Америкад гаргадаг байсан байна. 1930 онд тус пүүсийн байрыг улс хурааж тэнд гар үйлдвэрийн газар оруулсан нь 1950-иад онд 9-дүгээр артель гэж байгаад дөчин мянгатыг барих үеэр газарт оржээ.

Ланчансаны пүүсээс урагш усны гудамжны салаан дээр Германы «Востванк пүүсийн монгол дахь төв захиргаа нь байсны дээр мөн тэр хавьд хуучин Сайн ноён ханы хорооны дэвсгэрт 1927, 1928 оны үед «Спартак» хэмээх зочид буудлын хоёр давхар дүнгэн байшин барьжээ. Дараа нь зочид буудлын энэ байшин худалдааны ажилтан, ажилчдын нийтийн орон сууц болж хувирсан байна. Энэхүү Сайн ноён ханы хорооны хойт хэсэг буюу эдүгээгийн Улсын их дэлгүүрийн хавиас хойших хэсэгт гадаад дотоодын элдэв худалдаа үйлчилгээний газар байсны учир түүнийг «Сайн ноён ханы цоохор хороо юмуу «жасаа цоохор» гэж нэрлэхэд ч хүрч байжээ.

Дархан чин вангийн хорооноос баруун хойш Сайн ноён ханы хорооны зүүн хойт талаар Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хорооныхон байв. Энэ хорооны дэвсгэрт Америк улсын Андерсемярын пүүсийн монгол дахь төлөөлөгч «Ланчансан» хэмээх Ларисаны газрын кино танхим (сүүдэр шийний газар) байж орой бүр яндангийн дуунаар кино гаргалтаа зарладаг, тасалбар нь 20 мөнгөний үнэтэй байсан гэж Г. Ширмашин гуай ярьж байсан байна.

Энэ байшинд 1921 онд монголын харилцан туслалцах хоршоо байгуулагдсаны дээр хожим АРД кино театр, Хүүхдийн ба баримтат кино театр, эдүгээ үзэсгэлэнгийн газар тус тус байрлаж ирэв. Эндээс зүүн тийш Дүрслэх урлагийн музейн урд талаар дотроо олон байшинтай том хашааг оросын худалдаачин Басовын пүүс анх бариулсан бөгөөд 1919 оноос энд Гамингийн, дараа нь Барон унгерны цэргийн комендатур байрлаж байжээ. Хожим энд Худалдааны техникум байгуулагдаж олон жил байрласан байна. Мөн түүний зүүн өмнөх нэгэн гудамжинд Чулуучны газар байж, чулуу засах янзлах, хөшөө чулуу бүтээх ажлыг энд хийдэг байжээ. Бас Дайчин бэйсийн хорооноос урагш Дархан чин вангийн хорооны дэвсгэрт Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошууны тамгын газрын хар гэр (гяндан) байсныг ардын засгийн үед хүүхдийн хөдөлмөр хүмүүжлийн сургууль (колони) болгон өөрчилсөн байдаг.

Дархан чин ван, Баатар вангийн хорооны зүүн тал богдын залрах зам, зүүн хүрээний өмнөх их чөлөөний зүүн урдуурх хэдэн гудамжийг Түшээт хан аймгийн Дархан чин вангийн «Цоохор хороо» мөн аймгийн Бишрэлт гүнгийн хороо гэх мэтээр нэрлэдэг байжээ. Эдгээр хороодын зүүгээр Мал тариалангийн яам, Холбооны яам, Элдэв-Очирын нэрэмжит кино театр, «Алтай» зочид буудлын барилгууд болон дээрх хороодын зарим хэсгийг газарт оруулж орон сууцны барилгууд ч барьсан байна.

Их хүрээний харчуудын анхны хорооны нэг нь Түшээт хан аймгийн Түшээт ханы хороо байжээ. XIX зууны 2 дугаар хагаст хамаарах Их хүрээний зурагт энэ хороог зүүн хүрээний баруун этгээдэд нилээд онцгой тэмдэглэсэн байдаг. Жүгдэр, Маньбадар нарын бүтээсэн зургуудад Түшээт ханы хороог Төмөрчний гүүрээс зүүн хойш эдүгээгийн ахуйн үйлчилгээний ордны баруун хойдох, цэргийн оёдлын үйлдвэрийн хавьд байгаагаар тэмдэглэсэн байна.

Түшээт хан аймгийн суурин жасаа нь Хүнсний захын шар дэлгүүрийн архан хажууд байжээ. Энэ жасааны хашаанд 1919, 1920 оны үед дандаа хятад хүүхнүүд бүхий Эмсийн хүрээлэн энэ орчимд бас япон хүүхнүүдтэй өөр нэг Эмсийн хүрээлэн ажиллаж байжээ. Түшээт ханы хорооны эргэн тойронд хятад, оросын олон арван пүүс, дэлгүүр, үйлдвэр, үйлчилгээний газрууд монголчуудтай холилдон оршиж байсныг Түшээт ханы Цоохор хороо хэмээн нэрлэж байв. Энэхүү цоохор хорооны дэвсгэрт мөн аймгийн Сэцэн ван Гүрсоронзонгомбосүрэнгийн хошууны харьяат нар суудаг учир зарим тохиолдолд Сэцэн вангийн хороо ч гэж нэрлэх явдал байжээ. Энд 1919 оноос Швед улсын харъяат их эмч Герда Оллен, Грета Нильсон нар санаачлан хүн эмнэлгийн газар байгуулан хүрээнийхэнд үйлчилж эхэлсэн ба тус эмнэлэгт 1921 оноос швед бага эмч Гертруд Фольк ч ажиллаж байжээ. Түүнээс гадна 1923 онд мөн шведийн иргэн Дагни Хансен, Снгне Фольке, Магнус Берлунд нарын зэрэг багш нартай бага сургууль нээж түүнд монгол хүүхдүүдийг сургадаг байсныг 1924 онд хааж Швед улсын харъяат нарыг монголоос хөөж гаргасан тухай тэд эх орондоо очоод бичсэн байдаг.

Түшээт ханы хорооны өмнөх их гудамжийг Их зээл буюу Шинэ захын гудамж хэмээн нэрлэдэг байгаад хожим хотын захыг эдүгээгийн Зорчигч үйлчилгээний

төвийн зүүн талд шилжүүлснээс хойш үүнийг “Шинэ зах” Их зээлийг “Хуучин зах” хэмээн нэрлэдэг байсныг тавиад оныхон мэднэ. Хүрээний их зээлийн баруугаар байсан төмрийн дарханы газруудын дэргэдэх Баруун сэлбийн нэг гүүрийг Төмөрчний гүүр гэх бөгөөд энэ гүүр эдүгээгийн хүнсний захын шар дэлгүүрийн зүүн өмнө байв.

Хүнсний захын шар дэлгүүр байгаа энэ газар «Черты» хэмээх Копытовын их пүүсийн нэгэн байр байсны дээр эндээс зүүн тийш орос, хятад олон дэлгүүр байснаас Ахуй үйлчилгээний урт цагаан байшингийн зүүн үзүүр болох газар урьд Ягудины пүүсийн дэлгүүр байсныг ардын засгийн эхэн үед Зөвлөлтийн худалдааны «Сормонг» пүүсийн төв байр болгожээ. Ягудиний дэлгүүрийн зүүн талаар хүрээний их зээлээс баруун дамнуурчны Өргөн чөлөө уруу нэвтэрдэг гудамжийг тэр үед «Янчааны гудамж» энэ гудамжны аманд байсан Баруун сэлбийн нэг гүүрийг «Янчааны гүүр» хэмээн нэрлэдэг байв. Энэ гудамжинд оросын хөлсний хэдэн байшин байсны нэг Соловьевын байшинд зохиолч Д. Нацагдорж Нина гэдэгтэй ханилж байх үедээ суудаг байжээ. Тийм ч учраас Янчааны гудамжаас эхтэй гудамжийг 1990-ээд оны өмнө «Нацагдоржийн гудамж» хэмээн нэрлэж байгаад Сталины гудамжийг Нацагдоржийн нэрээр нэрлэснээс болж Баруун сэлбийн гудамж гэх боллоо.

Янчааны гудамжны хойд эхэнд Ван-шин-хуны пүүс баруун дамнуурчны өргөн чөлөө уруу харж байв. Түүний баруунтайх хэдэн пүүсийн байранд хожим нийслэлийн 5 дугаар дунд сургууль байжээ. Янчааны гудамжаас баруун сэлбэ хүрсэн хэсэгт дан ганц оросын хороолол байсны зүүн хойт буюу эдүгээ Барилгын зургийн институт байгаад 1862 оны үеэс үйл ажиллагаагаа хүрээнд явуулж эхэлсэн оросын худалдаачин Каковин, Басовын хувь нийлүүлсэн их пүүсийн төв байр байв. Хувьсгалын дараа энд Дотоод явдлын яамны «Одон хороо» байрлаж байжээ. Каковин, Басовын их пүүсээс баруун урагш Боловсролын хүрээлэнгийн орчимд байсан Богдановын пүүсийн байшинд 1918 онд «Центрсоюз» хэмээх Зөвлөлтийн худалдааны төв контор орсон бөгөөд энд Өвөр Монголын Ардын Хувьсгалт Намын анхдугаар их хурал хуралдсан байна. Мөн хорооллын хойт тал баруун дамнуурчны Өргөн чөлөөн дэхь байшинд 1921 оноос Монгол улсад суусан ЗОУ-ын

бүрэн эрхт төлөөлөгч В. И. Юдингийнх суудаг байсан бөгөөд хожим тэнд Монголын хувьсгалын музей байгуулсан байна. Энэ мэт оросын хорооллын байшингуудаас ганцхан Урманчеев, Серебюковын хувь нийлүүлсэн татар пүүсийн дэлгүүрийг эдүгээ номын дэлгүүр болгон ашиглаж буй болой.

Урманчеев нарын пүүсийн үүдээр өнгөрдөг Баруун сэлбэ голын урд дов дээр мах худалдаалдаг зах байсан учир «Махан дов» хэмээн нэрлэдэг байв. Махан довын зүүнтэйх хоёр давхар байшинд 1915 онд Орос-Монголын, худалдаа, аж үйлдвэрийн банк, дараа нь Гамин хятадын банк, Мал тариалангийн яам, Улсын их дэлгүүр зэрэг байгууллагууд байрлаж байгаад эдүгээ Дүрслэх урлагын музей оржээ. Эндээс зүүн тийш худалдаа хөгжлийн банк хавьд 1860-аад онд байгуулагдсан хүрээний орос бага сургууль, музейн хойд талд 1909 онд байгуулагдсан орос эмийн сан зэрэг олон газар ажиллаж байсны дээр энэхүү эмийн сангийн барилга одоо ч буй.

Монгол банк болон гутлын дэлгүүрийн орчимд «Хүрээний оросын хороо» нэртэй оросын харъяат олон айл байжээ. Энэ хороололд Австри улсын иргэн В. П. Генрих гэгч оросын нэг офицертой хувь нийлүүлж 1914 онд Ундаа, усны үйлдвэр байгуулсан байдаг.

Богд хаан Олноо өргөгдсөн Монгол улсын үед байгуулсан Гаалийн яамны харъяа Баруун гаалийн хороог Зүүн хүрээний өмнөх их чөлөөний баруун хойт талд байгуулсан нь эдүгээгийн Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны байр орчин дахь газар юм. Хүрээний орос хорооллын хойт этгээдэд хуучин хүрээ эргэх мөргөлийн зам дээр Дотоод явдлын яам болон түүний харъяа байгууллагуудын их барилгууд барьснаас хойш хуучин их зээлийг «Архангайн гудамж» хэмээн нэрлэх болсны дээр эдүгээгийн дүрслэх урлагийн музейн орчмоос Сүхбаатарын талбай хүрсэн шинэ гудамжинд чулуу дэвсэж, мод тарьж тохижуулаад «Лениний гудамж» нэр өгчээ. Дараа нь 1960-аад оноос хойш «Архангайн гудамж», «Лениний гудамж» гэсэн хоёр нэрийг нэгтгэн «Октябрийн гудамж» болгоод одоо энэ нэрийг бас өөрчилж «Худалдааны гудамж» гэх болов.

XIX зууны эхээр их хүрээний баруун талд Баруун дамнуурчин хэмээх хятад худалдаачин, гар урчуудын хороолол үүссэн байна. Баруун дамнуурчин нь 1839-

1855 оны хооронд улам өргөжин газар зүй, цаг уурын хувьд хамгийн нөмөр нөөлөг дулаан газрыг эзлэн бэхжиж, хүрээний нутаг уруу баруун талаас нь түрэх болжээ.

Их хүрээ ийнхүү Гандан хийдийн зүүн талд байршилтай болсноороо «Зүүн хүрээ» хэмээх нэртэй болж мөн тэр цагаас зүүн хүрээний харъяа болон тэр хавийн сүм хийдүүд, харчууд, гадаадын харъяат нарын хорооллуудыг хамтруулан <Богдын хүрээ> хэмээн монгол даяар нэрлэх болжээ.

Энэ үеэс Баруун дамнуурчин нь урд талаараа баруун дамнуурчны өргөн чөлөөгөөр Түшээт хан аймгийн Сэцэн вангийн хороо, Түшээт ханы суурин жасаа, Сахалын хэмээх хятад пүүс, зүүн талаараа зүүн хүрээ эргэх мөргөлийн замаар зүүн хүрээтэй, хойт талаараа Ногоон нуурын урд хөвөө, баруун хойт, баруун талаараа Зөөлөн хошууны зүүн бэлээр савласан нутагтай баруунаас зүүн чиг чиглэсэн 9 гудамж, энэ есөн гудамжийг хөндлөн огтолсон ганц урт гудамж бүхий хороолол байлаа. Зөөлөн хошууг хүрээнийхэн зааны хошуу шинжтэй хэмээн бэлэгшээж Гандан, Зүүн хүрээний лам нарын хооронд энд ном хаялцах тэмцээн явагддаг байсан хийгээд ийнхүү номын хүчээр маргалдаж уралдахыг тэр үе «Тасга хаялцах» тэмцээн гэж нэрлэдэг байжээ. Иймээс Зөөлөн хошууг Тасганы хошуу, Тасганы энгэр, дээр нь босгосон овоог Тасганы овоо гэх мэтээр нэрлэдэг болсон байна.

Баруун дамнуурчны өргөн чөлөөний нүүрэн дэх нарийн гудамжны хоёр гарт болон нэг гуравдах гудамжинд Бээжин Содномдаржаагийн пүүсийн хоёр салбар, мөн гуравдах гудамжинд өндөр Баянмөнх (Жень-ха-и), тарган Баярт (Дунь-фу-ю), нүүрний адаг хавьд Жин-жи-гүнс зэрэг хятадын 35 их пүүсийн салбар байв.

Эдгээрээс Да-шень-коугийн пүүс нь хүрээнд худалдаа хийдэггүй түүний дэлгүүрүүд нь Ховд, Улиастайд төвлөрч байсан бөгөөд зөвхөн түүний ар монголын аймаг хошуудад бараа гаргаж дамжуулдаг, хөдөөнөөс ирсэн жин хөсөг буудаг буудал нь энд байжээ.

Түүний зэрэгцээгээр 1915 оны үед л гэхэд арьс, шир боловсруулах хятад пүүсийн салбар хоёрдох гудамжинд нэг, гурав, зургаадах гудамжинд тус бүр 2, Мөнгөний дарханы газар нэг, гуравдах гудамжинд тус бүр 3, хоёрдох гудамжинд дөрөв байсан зэрэг баруун дамнуурчны 9 гудамжинд нийтдээ үйлдвэр,

үйлчилгээний 217 жижиг газар байв. Үүнийг гудамж гудамжаар нь авч үзвэл нэгдэх гудамжинд 19, хоёрдох гудамжид 37, гуравдах гудамжид 51, дөрөвдэхэд 16, тавдахад 37, зургаадахад 18, долоодоход 2, наймдахад 22, есдөхөд 15 байсан байна. Эдгээрт бүгд 495 хүн ажиллаж байжээ. Хятадын худалдааны хүрээн дэх бүх салбаруудын худалдан борлуулах бараа таваарын үнийн зохицуулалт хийж байдаг Шо-вон-куй хэмээх 12 даргын яам хоёрдох гудамжны эхнээсээ зургаа дах хашаанд байсан. Мөн хүрээнд хятадын гурван тсатр (ши-ёнз) байсны хоёр нь Наймаа хотод, нэг нь баруун дамнуурчны дөрөвдөх гудамжны баруун үзүүрт байжээ, Харин Наймаа хотоос Гэсэр сүмийг Баруун дамнуурчинд шилжүүлэн байрлуулах үед хоёрдох гудамжны эхэнд байсан Шинэ-бээжин пүүс өөрөөсөө хөрөнгө гаргаж Наймаад байсан хятад, театруудыг Баруун дамнуурчны өргөн чөлөөний урьд эхэнд шилжүүлэн барьсан нь саяхан болтол байсан байна.

XX зууны эхэн үед Баруун дамнуурчны зүүн урд талаар Америкийн нэгэн пүүсийн салбар байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд мөн энэ үед хүрээнд суудаг оросын нэгэн пүүсийн байрыг 1919 оноос хүрээний большевик оросууд клуб болгон засварлаж 1920, 1921 оны үеэс тус клубыг «Нардом» (Ардын ордон) хэмээн нэрлэдэг болжээ. Америкийн пүүсийн салбаруудын байранд хожим хөдөө аж ахуйн техникум байрлаж байгаад Сэлэнгэ аймаг уруу нүүсний нь дараа байранд нь цэргийн хэвлэх үйлдвэр орж, түүнийг одоогийн байрандаа орсоны дараа буурин дээр нь Гадаад худалдааны яамны өндөр барилга барьжээ. Мөн 1907 онд Копытов (Черты) хэмээх орос худалдаачны бариулсан дэн (зочид) буудлын хоёр давхар байшинг түүхийн дурсгалт газар болгон засварласан нь соёл үйлчилгээний «**Чандмань**» төвийн ар талд байдаг.

1921 оны хоёроос тавдугаар сард баруун дамнуурчны өргөн чөлөөнд (хилийн түүхийн музейн орчимд) Барон Унгерны байр байсан бол долдугаар сард энэ гудамжаар монгол, зөвлөлтийн цэргүүд Нийслэл хүрээндээ орж ирсэн түүхтэй.

Дараа нь Америкийн пүүсийн зүүхэнтэйд Нийслэл хүрээний комендант хавсарсан цагдан сэргийлэхийн хороо байрлах болж, бас өргөн чөлөөнд их зах нээж нэг морь, тэмээ, өвс, түлш, хоол хүнсний зүйл худалдаж байсан (45: 1-46-ын

21,22) гэх мэтээр нэгэн гудамжны түүх л гэхэд янз бүрийн үйл явдал болж байжээ.

1921 оны хувьсгалын дараахнаас баруун дамнуурчны өргөн чөлөөг «Коминтерн» гудамж хэмээн нэрлэсэн бол 1950-иад оноос «Мао-цзе-дуны», 1960-аад оноос «Найрамдлын» гудамж хэмээн нэрлэж байгаад Ж.Самбууг нас барсны дараа «Самбуугийн» гудамж гэх болов. Түүнээс гадна Чингэлтэй дүүргийн нутагт харийн түрэмгийлэгчид болон Хятадын шунахай худалдаачдын эсрэг хэд хэдэн удаа тэмцэл гарч байсан түүхт газар бий. Үүний заримаас дурьдахад 1907, 1908 оны үед монгол, хятад хүмүүсийн хооронд болсон их зодоон эдүгээгийн Их тойруу гудамж, Худалдааны гудамжны уулзвар хавьд болсон бол нөгөөх нь 1910 онд Баруун дамнуурчны өргөн чөлөөний дунд хавьд хойшоо харсан хүрэн дэлгүүрийн орчимд бас нэг их зодоон болж, түүнийг зохицуулахаар ирсэн манж амбаны сүйх тэргийг эвдэж түүнийг хөөж явуулсан байдаг. Тэгвэл үүнтэй төсөөтэй өөр нэг их тэмцэл эдүгээгийн Сүхбаатар дүүргийн нутагт байсан Богдын шар ордны үүдэнд 1919 онд болж Хятад улсын төрийн далбааг урж хаясан явдал юм. Ногоон нуурын хойд дэнжид 1950-иад онд барилгачдын нэгдсэн хорооны дан барилгууд барьж түүндээ «1000 айл» байрлуулснаар «Дэнжийн мянгат» хэмээх нэгэн хороолол болсоны дээр мөн үед хотын төв хэсгээс газарт орж нүүсэн айлуудаар «Булгын, Хайлаастайн» гэх мэт олон гудамж бүхий гэр хорооллууд Чингэлтэй уулын бэлээр бий болжээ.

Чингэлтэй уул бол үргэлжийн мөнхөд наран наадуулсан энгэр ээвэр, булаг шандаар баян, ургамал амьтнаар элбэг, үзэсгэлэнт сайхан хангай билээ. Чингэлтэй уулын ноён оргил нь далайн түвшнээс дээш 3000 орчим метрт өргөгдсөн, Хэнтийн уулын салбар, үзүүр бөгөөд тал талдаа Салхит, Хайлааст, Хайст, Баянцагаан, Сант, ар өвөр Гүнт, Хожуултын даваа, Жигжид, Шадувлин, суварган өндөр, Бумбат зэрэг олон сайхан үзэсгэлэнт амтай бөгөөд ам бүрээс ундрах булаг горхи нийлсээр Сэлбэ голыг үүсгэн хотын дундуур урсаж Хатан туулыг сэлбэдэг байна. Чингэлтэй уулын ар талын их Шинэсэн ой үргэлжилсээр Мөнх цаст Асралт хайрхан уул, Бухын зоо хэмээх ян хөвчтэй золгодог байна.

Чингэлтэй ууланд эм тангийн ургамал тухайлбал Гандигар, агь, сургар, дал, бамбай, цагаан төмс, нохойн хошуу, сэржмядаг, жамъянмядаг, юмдүүжин, юмангарав, банздуу, мөн голын усны захаар гонид , дэгд, башга зэрэг, маш олон ургамал ургадаг байна.

Чингэлтэй уулын орой бие нь тарган хонины ууц мэт тэв тэгшхэн агаад эрт дээрээс тахиж ирсэн 13 овоотой юм. Энэ уулыг намрын эхэн сард нэг удаа Их хүрээний зарим Дацан аймгууд, энгийн сүжигтэн ардууд овоог тахидаг байсан тухай бичсэн байдаг байна. Бидний өвөг дээдэс эрт дээр үеэс “Дөрвөн уулын сан” –гаас эхлээд нутаг орон уул усаа магтан дуулсан, ерөөсөн хайрласан, бэлгэдсэн ном судар зохиож тэр нь ард түмний дотор түгэн тархаж, бишрэл хүндэтгэл хүлээж зон олон маань уул ус, газар шороо, агаар тэнгэртээ сүсэглэн залбирч өөрийн ахуй амьдарлаа даатгаж, хайрлан хамгаалж ирсэн сайхан уламжлалтай билээ. Дөрвөн уулын шивдаг, савдаг гэж байдаг бөгөөд Шивдаг нь орны эзэн, савдаг нь уулын эзэн юм. Чингэлтэй уулын шивдаг нь ном барьсан эрдэмт лам, савдаг нь гахай байдаг гэсэн түүхтэй бөгөөд Чингэлтэй дүүргийн бэлгэ тэмдэг /эмбилем/-ийг зохиохдоо нар,сар, галын дор хүслийг хангагч чандмань эрдэнэ, түүний дор ариун тансаг цагаан бадам цэцэг, цэцгийн гол дундаас уулын савдаг гахай цухуйж байгаагаар хийсэн нь дээрх түүхтэй нарийн учгаар холбогдсон болой. Түүхийн баримтнаас үзвэл Чингэлтэй уулын Хайлаастын аманд 1885 онд 5 дугаар богд Жавзандамба, ван Юндэндорж нар 2-3 жил нямба хийж уйгаржин цагаан толгойг зохиож байжээ. 1930 аад оны үед Чингэлтэй ууланд Төвдийн Дамбаа лам, зурхайч гэвш Лувсанням гээд олон эрдэмтэн мэргэд номын далайд аялан бясалгал хийж байсан гэнэ. Эрдэм номын ухаан тэлэх бэлгэдэл бүхий энэ уулыг тойрсон олон аманд өөр өөрийн онцлог, дэг жаягтай сүм дуган, эрдэм номын төвүүд байжээ. Арван дөрөвдүгээр жарны улаагчин туулай жил 4 дүгээр богд Жавзандамба Чингэлтэй уулын “Улаан бумбат” гэдэг газарт билгэ зохист хэмээн Шадүбгэпилжанчүблин хийдийг барьсан нь дулба ёсны санваар сахилыг чанд сахигч гайхамшигт өвөрмөц дэгтэй сүм байсан гэсэн мэдээ байдаг байна. Энэ хийдэд хэдэн лам суудаг, нэг жимээр цувж явдаг, үдэш оройн цагаар эмс охид, харц ард, гадны хүнийг хүрээ

гороондоо хонуулдаггүй аглаг орон байсан гэж ярилцдаг билээ. Ийнхүү үзэсгэлэнт сайхан Чингэлтэй ууланд сүм хийд олноор байгуулж нямба бясалгал хийж, олон арван овоог тахиж байсан нь эрхэм энэ уулаа хайрлан хамгаалах өвгөд дээдсийн маань хэрсүү ухаантай холбоотой юм.

Шадүблин хийдэд мөргөл өргөл хийсэн хүмүүст тарган гонгор хэмээх шавар бурханыг бүтээж өгдөг байжээ. Гонгор бурханыг бүтээхэд ордог тэр шавар нь уг ууландаа байдаг хамгийн нарийн цагаан шавар байсан гэх мэдээ бий.

Зарим судлаачид, бичигчдийн ном судрыг сөхөж үзвэл Их хүрээг анхлан “Цэнгэлтэй” хэмээх билгэтэй сайхан нэртэй газарт байгуулахаар эрэн явсаар энд байгуулсан гэх боловч зарим эрдэмтэд “Чингэл” хэмээх ховор ургамал энэ ууланд их байснаас уг уулыг “Чингэлтэй” хэмээсэн гэсэн байдаг байна.

Дүүргийн билэг тэмдэг /Эмблем/-ийн тухай....

1992 оны Засаг дарга А.Зул, Хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Х.Төмөр нар дүүргийн сонинтой болох зорилгоор билэг тэмдэг буюу эмблемны загвар эскизийг соёмбо үсгийн дүрстэй адил хоёр баганын дунд “Чингэлтэй” гэсэн үгийг хуучин монгол бичгийн эвхмэл дөрвөлжин үсгээр бичээд дээр нь гал, нар, сар доор нь доош харсан зэв зураад түүнээ анхны сонинхоо нүүрэнд гаргасан байна. Ингээд анхны гаргасан эх загвараа гүнзгийрүүлж “Соёмбо” үсгийн ерөнхий загвараар хоёр баганын дунд “Чингэлтэй” гэсэн үсгийг эвхмэл дөрвөлжин үсгээр бичиж дээд талд нь гал, нар, сар буюу хүслийг хангагч Чандмань эрдэнэ, доод талд нь бадамлянхуа цэцэг байхаар төсөөлөн зурсан байна. Чингэлтэй уулын амин савдаг нь гахай буюу номч мэргэн лам бөгөөд энэ дүрсийг сонгож, ариун байгаль орчныг төлөөлөн хун цагаан бадамцэцэгийн дунд шингээн оруулж, бэлэгдлийн элгэнд “Чингэлтэй дүүрэг” хэмээн крилл үсгээр бичин билэгдэл тэмдгийн оройд гурван үеийн турш нар шиг мандаж, сар шиг гийгүүлж, гал шиг өөдөө дүрэлзэн бадарч байх утгыг илэрхийлж, тэдгээр дүрсийг залснаар дүүргийн бэлэг тэмдгийн эх загвар батлагдан гарсан байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үүсэл хөгжил...

Чингэлтэй дүүрэг нь Нийслэл Улаанбаатар хотын түүхэн хөгжилтэй салшгүй холбоотой, түүний бүрэлдэхүүн хэсэг мөн. Нийслэл Улаанбаатар хотын үүсэл

түүхэн хөгжил нь 1639 оноос эхлэх бөгөөд энэ хугацаанд Өргөө, Их хүрээ, Нийслэл хүрээ, Улаанбаатар гэсэн олон нэрийг авч нүүж, суурьшин, хөгжиж цэцэглэсээр өнөөг хүрсэн байна. 1989-1990 оноос Улаанбаатар хотод ардчилалын шинэ хөдөлгөөн үүсч, Монголын ардчилсан холбоо, Монголын ардчилсан социалист хөдөлгөөнүүд нь ардчилал эрх чөлөө, хөгжлийн шинэ замаар дэлхийн улс орнуудтай мөр зэрэгцэн явахаар шинэ дэвшилийг зохион байгуулж, 1990 онд анх удаа олон намын оролцоотой ардчилсан сонгууль явагдсан байна. Энэ сонгуулийн үр дүнд Монголд анх удаа байнгын ажиллагаатай олон намын бүрэлдэхүүнтэй парламент Улсын бага хурал байгуулагдсан бөгөөд 1992 оны 1 сарын 13-ны өдөр монгол улсын шинэ үндсэн хуулийг батлуулсан байна. Энэхүү шинэ үндсэн хуульд Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг тогтоож хуваарилахдаа Монгол улсын нутаг дэвсгэр нь аймаг, нийслэлд эхлэн хуваагдаж аймгийн нутаг нь сумдад, Нийслэлийн нутаг нь дүүрэгт хуваагдахаар зааж тэдгээрийг хилийн цэсийг засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их хурал баталж байхаар тогтоосон байна. Мөн хуульд аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн гээд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ гэж заасны дагуу Монгол улсын Их хурлаас 1992 онд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийг батлан гаргаж дээрх хуулиудыг үндэслэн Монгол улсын Их хурлаас Улаанбаатар хотын районуудыг хүн, ам хороодынхоо тоогоор ойролцоо төвийн болон захын гэсэн 12 дүүрэг байхаар тогтоосон бөгөөд 1992 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Сүхбаатар дүүргийг Чингэлтэй, Сүхбаатар гэж 2 дүүрэг болгон зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна. Монгол улсын үндсэн хууль болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд зааснаар юуны өмнө нутгийн өөрөө удирдах байгууллага болох Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг байгуулах ажилд орсон юм.

Чингэлтэй дүүргийг шинээр салгаж зохион байгуулах ажлыг Сүхбаатарын районы АДХ болон гүйцэтгэх захиргааны удирдлага зохион байгуулж,

Улаанбаатар хотын АДХ-ын тэргүүлэгчдийн 1992 оны 09 сарын 01-ны 31 дүгээр тогтоолоор Чингэлтэй дүүрэгт засаг захиргааны нэгж 18 хороо байхаар тогтоосон учир хороодын иргэдийн нийтийн хурлыг тэр үеийн ОСГ-ны хороодыг түшиглэн зохион байгуулжээ.

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай 1996 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр тогтоолд Чингэлтэй дүүргийн хилийн цэсийг: Чингэлтэй уул /1949,7/, Гүнтийн даваа, Хужиртын даваа /1760,9, 1702,0 тоотууд/, Хадлангийн даваа, Сэлбийн голоор уруудан Дамбадаржаагийн гүүр хүрч засмар замаар 7 буудал, 5 буудлаар дайран 32-ын тойргоор баруун тийш эргэж Дэнжийн 1000-ын урд талын засмалаар явж орон сууцны 6 дугаар хорооллын арын замын уулзвар хүрнэ. Үүнээс зүүн тийш явж Сүхбаатарын гудамжаар эргэн Энхтайваны өргөн чөлөөгөөр баруун тийш, баруун дөрвөн замын уулзвар хүрч, их тойруугаар Гэсэр сүм, Хувьсгалчдын замаар хойшоо эргэн Зурагтын эцсийн буудлын хойд гүүр, Мааньтын хөтөл, Хамба толгой /1686,0/ Байшинтын гозгор уулаас Чингэлтэй уул хүртэл гэсэн байдлаар тогтоосон байна. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дээр Засаг захиргааны 19 нэгж хороо байрлаж .. мянган өрхийн гаруй мянган иргэд аж төрж байна. Тус дүүргийн нутаг дэвсгэр, үйлдвэр, үйлчилгээ, худалдааны байгууллага, төрийн яам, газар, олон нийтийн байгууллагууд оршин байрлаж, үйл ажиллагаа явуулж байдаг төвийн дүүргийн нэг юм. Дүүргийн анхны иргэдийн төлөөлөгчдийн хурал 1992 оны 09 дүгээр сарын 19 нд Сүхбаатар дүүргийн хурлын зааланд болж зохион байгуулалтын асуудлыг хэлэлцсэн бөгөөд хуралд 19 хорооны 2023 иргэд оролцсон хурлаас сонгогдсон 95 төлөөлөгч оролцсон байна. Төлөөлөгчдийн дотор эрэгтэй 82, эмэгтэй 13, ажилчин 6, албан хаагч, сэхээтэн 29, удирдах ажилтан 18, өндөр настан 12 хүн байсан бөгөөд тэдгээр төлөөлөгчдийн сонгуулийн материалыг шалгаж танилцаад бүрэн эрхийг зөвшөөрсөн байна. Ингээд Сүхбаатар районы АДХ-ын тэргүүлэгчдийн орлогч даргаар ажиллаж байсан хуульч Дамбадаржаагийн Тогтохжаргалыг Чингэлтэй дүүргийн ИТХ-ын даргаар, Нарийн бичгийн даргаар мөн АДХ-ын нарийн бичгээр ажиллаж байсан Х.Төмөр нарыг сонгуулах санал гарган хэлэлцүүлж соёрхон батлуулсан байна. Харин тэргүүлэгч гишүүдээр хошууч генерал Саандар,

ариун цэвэр халдвар судлалын эмч Үржээ, Зам тээврийн яамны ажилтан Сүрэн, Улсын төлөвлөгөөний комиссын ажилтан Болд, 37 дугаар сургуулийн захирал Пүрэвдорж, Шаазангийн үйлдвэрийн ажилтан Туяа, Автобусны 2 дугаар конторын ажилтан Сосор, Эрүүл мэндийн 3 дугаар төвийн дарга Түмэндэлгэр, байцаагч Батдорж нарын нэрийг дэвшүүлэн хэлэлцээд Саандар, Сүрэн, Болд, Пүрэвдорж, Батдорж, Түмэндэлгэр нарыг тэргүүлэгч гишүүнээр сонгон баталсан байна.

Тус хуралдаанаар хэлэлцэх дараагийн асуудал нь дүүргийн засаг даргыг сонгон дэвшүүлэх байсан бөгөөд Сүхбаатар районы орлогч дарга Алаг овогтой Зул, Хөдөлмөр нийгэм, хангамжийн яамны хүн ам зүйн газрын дэд дарга Содовсүрэн овогтой Нармандах, Сүхбаатар районы Засаг захиргааны хэлтсийн зохион байгуулагч Журамт овогтой Оргил нар нэр дэвшигдэн тус бүрийн үйл ажиллагааны хөтөлбөр танилцуулсан бөгөөд нууцаар санал хураалтад 82 гишүүн оролцсоноос А.Зул 44 гишүүн буюу 55 %, С.Нармандахад 30 гишүүн буюу 37%, Ж.Оргилд 6 гишүүн буюу 7,5% нь тус тус санал өгч Алагийн Зул Чингэлтэй дүүргийн Засаг даргад нэр дэвшигдэн сонгогдсон байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт гэрийн 12, орон сууцны 6 бүгд 18 хороо байрлаж, 22210 гаруй өрхийн 97956 хүн ам оршин сууж байсан бөгөөд 9340 толгой мал, улсын үйлдвэрийн газар- 93, хувийн хоршоо компани 390, хувиараа эрхлэх аж ахуй 1319 бүгд 1300 гаруй байгууллага аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг байв. Мөн Ерөнхий боловсролын сургууль 11, цэцэрлэг 19, ясли 3, хүнсний дэлгүүр 19, аж үйлдвэрийн барааны дэлгүүр 17, нийтийн хоолны цэг салбар 14 ажиллаж байлаа. Дүүргийн Засаг даргын зөвлөлийн анхны хурал СБД-ийн орлогч даргын өрөөнд 1992 оны 10 сарын 02-нд болж Засаг дарга А.Зул, Орлогч дарга М.Энхболд Засаг захиргааны хэлтсийн дарга Ч.Дашлхагва, аж ахуйн тасгийн дарга М.Магнайдорж, Дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга Д.Тогтохжаргал, тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Х.Төмөр нарын бүрэлдэхүүнтэй болж хороодын иргэдийн хурлаас сонгогдсон Д.Дашхорлоо, Х.Цогтбаяр, Н. Одонтунгалаг, Д.Цэнжав, С.Пүрэвсүрэн, Д.Цэвлээ, И.Цагаач, Г.Цэндсүрэн, Т.Түвшинжаргал, И.Төмөрбаатар, Г.Шагдар, Г.Энхбаяр, Б.Төмөр, Ж.Гандан, С.Дагвадорж, Ё.Даваа, Ц.Пүрэвбаатар, Ц.Нацагдорж нарыг хороодын Иргэдийн

Нийтийн хурлаас ирүүлсэн саналыг үндэслэн 18 хороодын засаг даргаар хэлэлцэн баталж томилсон байна. Дүүрэг байгуулагдаж Улаанбаатар хотын Засаг даргын 1992 оны 11 сарын 05-ны өдрийн а/38 дугаар захирамжаар ОСНАА-н компани байрлаж байсан Сүхбаатарын гудамжны 7 дугаар байшинг блансаар шилжүүлэн өгч Тамгын газрын контор болгон ашиглуулсан бөгөөд энэ байранд 1992 оны 10 сарын 25-ны өдөр дүүргийн Засаг даргын албан конторт тавилга тавьж шаваа тавин үйл ажиллагаагаа эхлүүлсэн түүхтэй юм. Нийслэлийн Засаг даргын 1992 оны б/212 дугаар захирамжаар батлагдсан орон тоо, цалингийн фондыг үндэслэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн орон тоонд ажиллах хүмүүсийг дүүргийн Засаг даргын 1992 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 04 тоот захирамжийн дагуу доорхи бүрэлдэхүүнээр томилсон байна.

Дүүргийн Тамгын газрын зохион байгуулалт бүтэц

1. Дүүргийн Засаг дарга
2. Засаг даргын орлогч
3. Тамгын газрын дарга бөгөөд Засаг захиргааны хэлтсийн дарга

Тамгын газар нь 6 хэлтэс, 1 тасагтай.

1. Засаг захиргааны хэлтэс 24 албан хаагч болон аж ахуйн тасагтай
2. Санхүүгийн хэлтэс 7 албан хаагчтай
3. Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс 8 албан хаагчтай
4. Цэрэг иргэний хамгаалалтын хэлтэс 5 албан хаагчтай
5. Хүн амын бодлого, хөдөлмөрийн хэлтэс 14 албан хаагчтай
6. Хянан байцаах хэлтэс 5 албан хаагчтай
7. Статистик мэдээллийн тасаг 4 албан хаагчтай тус тус байгуулагдсан.

Энэ үед Засаг дарга А.Зул, Орлогч дарга М.Энхболд, Тамгын газрын дарга бөгөөд засаг захиргааны хэлтсийн даргаар Ч.Дашлхагва нар ажиллаж, Тамгын газрын хэмжээгээр нийт 67 ажилтан албан хаагчтайгаар ажлаа эхлүүлжээ.

Хэлтсүүдийн ажилтан нарыг тодорхойлвол:

Засаг захиргааны хэлтэст:

1. Дарга Ч.Дашлхагва

3. Төсвийн мэргэжилтэн Б.Мятавсүрэн
4. Бүртгэлийн мэргэжилтэн Ш.Сэргэлэн
5. Оператор нябо Эрдэнэтөгс
6. Хяналтын байцаагч Х.Чансаа
7. Хяналтын байцаагч Шүрэнцэцэг

Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэст:

1. Дарга Р.Дархижав
2. Нийтийн хоол худалдаа хариуцсан зохион байгуулагч Л.Мөнхөө
3. Худалдаа хариуцсан зохион байгуулагч Д.Цэенхорлоо
4. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан зохион байгуулагч Н.Наранцэцэг
5. Байгаль орчин, газар эдэлбэр хариуцсан зохион байгуулагч Ц.Жаргал
6. Холбоо тээвэр, орон сууц ахуй үйлчилгээ хариуцсан зохион байгуулагч Б.Цэнгэл
7. Ахлах мэргэжилтэн Ч.Чулуунбат

Цэрэг иргэний хамгаалалтын хэлтэст:

1. Дарга хошууч Л.Батболд
2. Дайчилгааны асуудал хариуцсан офицер ахмад Н.Сэрсэндэмэд
3. Тоо бүртгэл хариуцсан офицер ахмад Индраавал
4. Иргэний хамгаалалтын штабын дарга хурандаа Б.Дүүрэнбилэг
5. Иргэний хамгаалалтын сургалт бэлэн байдлын офицер хошууч А.Дамцагдорж

Хүн амын бодлого хөдөлмөрийн хэлтэст:

1. Дарга Ч.Солонго
2. Нябо Ч.Нэргүй
3. Байцаагч Д.Буянтогтох
4. Байцаагч Д.Мягмарсүрэн
5. Байцаагч Г.Жаргалсүрэн
6. Байцаагч Ч.Отгонбаяр
7. Байцаагч Б.Шүрэнцэцэг
8. Халамжийн асуудал хариуцсан байцаагч З.Тоня

9. Шимтгэлийн байцаагч нябо Г.Янжинхүү
10. Шимтгэлийн байцаагч Цэцэгмаа
11. Шимтгэлийн байцаагч Х.Наранцэцэг
12. Оператор нябо Ц.Цолмон
13. Байцаагч Ц.Одончимэг
14. Байцаагч Ч.Уранчимэг

Хянан байцаах хэлтэс

1. Дарга Д.Дамба
2. Ахлах байцаагч Т.Шаапаа
3. Хяналт шалгалтын байцаагч Бадамгарав
4. Хяналт шалгалтын байцаагч Оюунцэцэг
5. Хяналт шалгалтын байцаагч Чулуунбат

Статистик мэдээллийн тасаг

1. Дарга Ц.Энхбаяр
2. Оператор Д.Энхтуяа
3. Мэргэжилтэн Д.Адилбиш
4. Мэргэжилтэн Ж.Галя

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц нь төрийн яамд, засаг захиргааны байгууллагын аппаратын орон тоог цомхотгох, чадваржуулах бодлогоос гадуур байгаагүй бөгөөд орон тоог 3 удаа цомхотгож, хүн амын бодлого, хөдөлмөрийн хэлтэс нь дүүргийн засаг даргын дэргэдэх биеэ даасан хэлтэс болж, хянан байцаах хэлтэс нь татан буугдаж, цэрэг иргэний хамгаалалтын хэлтэс нь Засаг захиргааны хэлтэст нэгдэж, Статистик мэдээллийн тасаг нь Эдийн засаг нийгмийн хэлтэс болон эдийн засагчаар Чанлуулалодой , хөдөлмөр хамгаалалын улсын байцаагч нар Ю.Энхжаргал нар нэмэгдэн томилогдсоноор тамгын газар, засаг захиргаа, үйлдвэрлэл үйлчилгээний, эдийн засаг нийгмийн хэлтсүүдийн эрхлэх ажлын хүрээ, гүйцэтгэх үүрэгт нилээд өөрчлөлт орсон юм.

Цэрэг Иргэний хамгаалалын офицер хурандаа Дүүрэнбилэг, Сэрсэндэмид, Индраабал нар шилжиж оронд нь хошууч А.Дамцагдорж, Цэрэндаваа нар ЗЗХ –т шинээр томилогдон ирсэн.

Ингээд анх 6 хэлтэс, 1 тасагтай 67 ажилтан, ажилчидтай байснаа 4 хэлтэс 43 ажилтантайгаар ажиллаж ирсэн байна. Дүүрэг шинээр байгуулагдсантай холбогдож, Засаг даргын дэргэд албан татвар, Нийгмийн даатгал, Цагдаагийн хэлтэс, Замын цагдаагийн тасаг, Эрүүл ахуй халдвар судлал хяналтын алба, Мал эмнэлэг үржлийн алба, Хүүхдийн байгууллага, Тохижилт үйлчилгээний компани, Дүүргийн шүүх, Прокурорыг шинээр байгуулагдсан байна. Дүүргийн Тамгын газар байгуулагдсан цагаасаа эхлэн дотоод журам боловсруулан мөрдөж, хэлтэс, хороодын ажлыг хагас бүтэн жилээр, байр эзлүүлэн дүгнэх болзолт журам гаргаж мөрдөж ажиллаж ирсэн нь байгууллага дотооддоо дэг журмыг чанд сахих, ажил хэргээ эмх цэгцтэй, холбогдох хууль, дүрмийн дагуу явуулах, аливаа асуудалд шуурхай хандахад чухал нөлөө үзүүлсэн юм. Монгол улсын төрийн албаны тухай хууль анх гарснаар тамгын газрын 23 ажилтан 1995 оны 6 дугаар сарын 8 нд төрийн албан хаагчийн тангараг өргөж, мөн зэрэг дэв, удаан жилийн нэмэгдэл хөлс олгох болсон нь тэдний ажлын идэвхи санаачлага, сахилга хариуцлагыг өндөржүүлэх засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чухал хүчин зүйл болсон байна. Төр захиргааны байгууллагын ажлыг сайжруулж, сахилга дэг журмыг бэхжүүлэх чиглэлийн дор Тамгын газрын орон тоо зохион байгуулалтыг боловсронгуй болгох, төрийн хууль тогтоомжийг сурталчилан хэрэгжүүлэх, Тамгын газар, хороодыг чадварлаг боловсон хүчнээр бүрдүүлж, тэдний мэдлэг мэргэжлийг системтэй дээшлүүлэх, сахилга дэг журмыг сайжруулж, дүүргийн хууль хяналтын байгууллагын ажилд тусалж материаллаг баазыг нь бэхжүүлэхэд анхаарч ажилласан юм.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан ажлын талаар:

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын талаар

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хөдөлмөр Халамж, Үйлчилгээний газраас “Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем”-ийг орчин үеийн мэдээллийн технологид түшиглэн бий болгосноор Хөдөлмөрийн төв

биржийн “Мэдээллийн нэгдсэн сан”-д ажил хайгчийн болон ажил олгогчийн, ажлын байрны, ажил мэргэжлийн тоон үзүүлэлтүүдийг цуглуулах, боловсруулах, хадгалах зэрэг мэдээллүүдийг бүрдүүлэн ажилласнаар ажил идэвхитэй хайж буй 3027 хүний мэдээллийг Хөдөлмөрийн зах зээлийн менежер программ болон Labornetwork санд оруулж, мэргэжил боловсрол, ажлын дадлага, ур чадварыг нь харгалзан 2320 хүнийг ажил олгогчийн шаардлагад нийцүүлэн ажил, хөдөлмөрт зуучлаад байна.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд бий болсон нийт 5146 шинэ ажлын байрыг бүртгэн хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан Ejob.mn. сайтад байрлуулсан бөгөөд шинээр ажлын байруудыг нээж ажиллуулахад онцгой анхаарч ажилласан байна.



Үр дүнгийн гэрээний талаар:

Монгол Улсын Санхүү, Эдийн засгийн сайдын 2002 оны 355 тоот тушаалаар батлагдсан гэрээний зааврын дагуу Дүүргийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээг байгуулан хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 187 дугаар тогтоолын дагуу 16 заалт бүхий нийт 225 бүтээгдэхүүний гэрээг байгуулан ажилласнаар хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган тооцож ажилласан ба Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсөвт байгууллагууд болон хувийн сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэгийн захирал, эрхлэгч, дарга, хороодын Засаг дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэлт, үр дүнгийн гэрээг байгуулан ажиллаж байна.

Төрийн албан хаагчдын ажил дүгнэх аргачлал, үзүүлэлтийн системийг шинэчлэн боловсруулж, ажлын эцсийн үр дүн, бүтээлч санаачлагыг түлхүү урамшуулах бодлогын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2007 оны 48, 2009 оны 187 дугаар тогтоолуудыг мөрдлөг болгон төрийн албан хаагч бүртэй бүтээгдэхүүн нийлүүлэлт, үр дүнгийн гэрээг байгуулан хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн байдлаар тооцон дүгнэж ажиллаж байна.

Төрийн захиргааны ажлын чиглэлээр:

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас Мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх замаар үнэн зөв бүртгэл мэдээлэлд суурилсан үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор дүүргийн “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-г хороо бүрт бий болгон, “Цахим засаглал” хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг зорин ажилласнаар 34466 өрхийн 136665 хүн амыг шивж программд оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Дүүргийн “Нэг цонхны үйлчилгээний төв”-ийн үйл ажиллагаа тогтмолжиж иргэдэд төрийн ажил, үйлчилгээг хүнд суртал чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх нөхцөл бүрдсэн ба тус танхимд Хөдөлмөр халамж үйлчилгээний болон Татварын хэлтэс, Нийгмийн даатгал, Санхүү төрийн сан, Онцгой байдлын хэлтсийн ажилтнууд болон Нотариат, банк зэрэг нэг дор байрлан ажилласнаар иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Төрийн үйлчилгээний болон цаг үеийн мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор мессежны системийг “Иргэдийн мэдээллийн сан”-тай холбон нэвтрүүлж, мөн Монгол улсын хүний аюулгүй байдлын төвийн санаачлагаар тус дүүргийн 12 дугаар хороонд Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Нэг цонхны үйлчилгээний танхим”-ыг байгуулан иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх үйл ажиллагааг эхлүүлээд байна.



Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газраас Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор Засаг даргын 2010 оны 168 дугаар захирамжийг гарган ажилтан албан хаагчдыг орон сууцжуулахаар хотын төвийн А зэрэглэлийн байрлалд 60 айлын орон сууцны барилгыг бариулж 1м²-ын үнэлгээг зах зээлийн хамгийн бага өртгөөр тооцон орон сууцны квот олгон 2011 оны төсвийн тодотголоор 190 сая төгрөгийг шийдүүлсэн. Ажилтнуудын амины

хэрэгцээнд зориулж газар эзэмшүүлэхээр 37 ажилтанд “Гэрчилгээ” олгох ажлыг зохион байгуулсан байна.

Иргэний бүртгэлийн ажлын чиглэлээр:

Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай болон Улсын бүртгэлийн ерөнхий хууль бусад хууль, тогтоомж, заавар журмын хүрээнд шинэ төрөлт, шинэ эцэг тогтоолт, хугацаа хэтэрсэн төрөлт, гэрлэлт, хуучин эцэг тогтоолт, гэр бүл цуцлалт, хүүхэд үрчлэлт, овог нэр, нэр солилт, засвар өөрчлөлт, баталгааны дахин олголт, гэрчилгээний дахин олголтын зэрэг бүртгэлүүдийг хийж ажиллаж байна.

Төрийн захиргааны салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 50,0 сая төгрөг, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 850,0 сая, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,1 тэрбум, төсөл хөтөлбөрөөр 45,0 сая төгрөг буюу нийт 2,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдлээ.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсвийн орлого, зарлагын чиглэлээр:

Чингэлтэй дүүрэгт 2011 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн орлого 7,618,468,1 мянган төгрөгөөр төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 9.800.023.6 мянган төгрөгийн буюу 117,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

2011 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар нийт 15479 ширхэг баримтаар 78 тэрбум 968,1 сая төгрөгийн орлогын гүйлгээ, 93018 ширхэг баримтаар 80 тэрбум 848,1 сая төгрөгийн зарлагын гүйлгээг хийсэн. Энэ хугацаанд баримтын зөрчил дутагдал залруулгын гүйлгээ гаргах явдлыг багасган ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын чиглэлээр:


- Мөсөн гулгуурын талбайтай спортын төв байгуулах ажил
- Тусгаар тогтнолын талбайн гэрэлт хөшөөний ажил,
- Бага тойруугийн гудамжны тохижилтын ажил,
- Б.Явуухулангийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт,
- Явган замын хүрээнд хийгдэх тохижилт,
- Цэцгийн баяр, цэцгийн мандал байгуулах ажил,
- Самбуугийн гудамжны тохижилт,
- Чоймболын гудамжны тохижилт,

- 1 дүгээр хорооны байрнууд дундах бичил цэцэрлэгийн тохижилтын ажлуудыг 100 хувь хийж дуусгасан байна.


Татвар төлөлтийн талаар:

Д/д	Татварын нэр төрөл	Төлөвлөгөө	Өссөн нийт гүйцэтгэл	Өссөн хувь
1.	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	20,166,735,3	18,446,147,3	91,5
2.	Улсын тэмдэгтийн хураамж	5,216,056,9	6,736,044,3	129,1
3.	Хүү торгуулийн орлого	550,000,0	795,522,3	144,6
4.	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,446,210,1	1,412,839,9	97,7
5.	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	988,757,4	1,020,929,1	103,3
6.	Нийт орлогын дүн	60,870,344,3	58,451,334,9	96,0

Тэтгэвэр авагчдын тоо, олгосон тэтгэвэр /5 жилийн үзүүлэлтээр/



Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан тэтгэмж /5 жилийн үзүүлэлтээр/



Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Эрхзүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр:

Дүүргийн хууль хяналтын байгууллагын ажилтнуудын хамтын хүчээр өдөрлөг, зөвлөгөөн, нээлттэй хэлэлцүүлэг, уулзалт, ярилцлага, албан бус сургалтуудыг тогтмол зохион байгуулж, байгууллагуудаас хийж хэрэгжүүлж буй ажил, цаашдын бодлого, зорилтын талаар төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллаж байна.

“Эрх зүйн туслалцааны төв”-ийн өмгөөлөгчөөс Эрүүгийн хэргийн холбогдолтой хэргүүдийг хүлээн авч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн шатанд өмгөөллийн үйл ажиллагааг үзүүлсэн ба төвд хандсан иргэдэд эрүү, иргэн, захиргааны чиглэлээр хууль зүйн анхан шатны зөвлөгөөг өгч ажиллаж байна. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөл, Засаг даргын Тамгын газар, Монголын Өмгөөлөгчдийн холбооны “Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцах хороо”, Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлтэй тогтмол хамтран ажиллаж, дүүргийн иргэдэд эрхзүйн үнэ төлбөргүй туслалцаа”-г үзүүлж, эрх зүйн албан бус сургалтыг зохион явуулж байна.

Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Боловсролын чиглэлээр:

Дүүргийн хэмжээнд төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 22 сургуулийн 670 бүлэгт 22117 сурагч, 21 цэцэрлэгийн 154 бүлэгт 6309 хүүхэд, хувилбарт сургалтанд 10 бүлгийн 288 хүүхэд тус тус суралцаж байна. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 57,1 хувь болж дундаж үзүүлэлтээс 8, 8 хувиар өссөн байна.

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	Дундаж өсөлт, бууралт хувь
ЕБС-д	20634	26297	26919	24530	7.0

хамрагдсан хүүхэд					
Эрэгтэй	9957	11285	13406	12213	7.7
Эмэгтэй	10677	12051	13516	12536	5.9
СӨБ-д	3302	5308	5636	6543	27.7
хамрагдсан хүүхэд					
Эрэгтэй	1565	2617	2756	3379	31.7
Эмэгтэй	1737	2691	2877	3217	24.6
Сургууль	95	87	38	45	(15.4)
завсардсан хүүхэд					
Эрэгтэй	54	51	27	34	(8.9)
Эмэгтэй	41	36	11	11	(27.2)
СӨБ-д	3299	4312	3625	3129	0.4
хамрагдаагүй хүүхэд					
Эрэгтэй	1518	1769	1813	1774	5.6
Эмэгтэй	1791	1843	1810	1606	(3.4)

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн чиглэлээр:

Хүүхэд, багачуудын эсэн мэнд өсөн бойжих, амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд идэвхитэй оролцох эрхийг хангах, аж байдлыг сайжруулах, өөрчлөлт, дэвшил гаргахад бодит хувь нэмэр оруулахад “Хүүхэд хамгааллын үйлчилгээ” болон “Хамтарсан багийн үйл ажиллагааны талаар” сурталчилгаа зохион байгуулж үйл ажиллагааг тогмолжуулан ажиллаж байна.

“Монголын өсвөр үеийнхний Хөгжлийн үйлчилгээний Төв” нь ХБНГУ-ын Коелэрийн гэр бүл болон Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Хайлааст орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр дүүргийн 18 дугаар хороонд “E-Smile” интернэт сургалтын төвийг 2011 оны 8 дугаар сарын 29-ны өдөр нээсэн бөгөөд тус дүүргийн 17, 18 дугаар хорооны хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, мэдээлэл авах, мэдлэг, чадвараа дээшлүүлэх орчин болсоноороо ач холбогдолтой юм.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Монгол Улсын засгийн газрын мөрийн хөтөлбөр, нийслэл дүүргийн нийгэм эдийн засгийн зорилт, Нийслэлийн Эрүүл Мэндийн газрын бодлого, чиглэлийн хүрээнд хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, үйлчлүүлэгчдэд ээлтэй, тэгш, чанартай тусламж, үйлчилгээг хүргэх зорилгоор дүүргийн Эрүүл Мэндийн Нэгдэл нь дүүргийн хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан, хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг өрхийн эмнэлэг, нарийн мэргэжлийн поликлиник, салбар амбулатори II, хэвтэн эмчлүүлэх 227 ортой эмнэлгүүдээр дамжуулан эмнэлгийн дээд мэргэжилтэн их эмч эмнэлгийн дунд мэргэжилтэн , туслах болон үйлчилгээний ажиллагсдын хүчээр хүргэж байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Гэмтэл, мэс заслын төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх 20 ортой тасгийг салбар 1 дүгээр Амбулаторид байгуулан ЭМШУИС-тай хамтран дурангийн өдрийн мэс засал, Гэмтэл согог судлалын Үндэсний төвтэй хамтран гэмтлийн тусламж үйлчилгээг хэрэгжүүлэхээр судалгааг хийн 2012 оноос үйл ажиллагааг эхлүүлэхээр ажиллаж байна.

Эрүүл мэндийн нэгдэлд “Эмэгтэйчүүд”, “Хүүхэд, өсвөр үе”, “Сэтгэц наркологи”, “ХДХВ/ДОХ-ын диспансер” зэрэг кабинетуудийг байгуулсан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	Дундаж өсөлт, бууралт хувь
Эхийн эндэгдэл	0	3	1	4	44.4
Нярайн эндэгдэл	12	17	25	12	12.2
5 хүртэл насны хүүхдийн нас баралт	3	43	20	55	484.9
Байнгын асаргаанд байгаа хүний тоо	401	610	995	1023	39.3
0-5 нас	23	18	47	41	42.2
6-14 нас	20	29	52	79	58.7

15-60 нас	160	223	382	395	38.0
60-аас дээш насны	188	301	525	508	43.8
Байнгын асаргаанд байгаа ХБИ	130	226	358	418	49.7
16-60 нас	126	156	254	292	33.9
60-аас дээш	61	142	142	218	62.1


Гадаад, дотоодын Олон Улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хүрээнд нийт 193,798,418 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн нэгдэлд нийлүүлсэн ба “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-3” төслийн хүрээнд нийт 350 сая гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтаар сэргээн засах, физик эмчилгээ, нүд, чих хамар хоолой, дүрс оношлогоо, лаборатори, дотор, мэдрэл, мэс засал, ариутгал, халдваргүйжүүлэлт, анхны тусламж зэрэг 40 нэр төрлийн, 422 ширхэг эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсанаар эмчилгээ оношлогооны нэр төрөл нэмэгдэж чанар хүртээмж нь сайжирсан. Мөн гематологи, серологи, ДОХ, сүрьеэ, биохими, иммунологи, бактериологи зэрэг шинжилгээнүүдийг хийж байна.

Дүүргийн Эрүүл Мэндийн Нэгдлийн болон өрхийн эмч нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага, Канадын Сан, Азийн Сангийн тусламж дэмжлэгтэйгээр “Анагаах Ухааны Мэдээллийн Төв”-ийг байгуулж, 5,000 гаруй долларын үнэ бүхий мэргэжлийн ном, сурах бичиг, сэтгүүл, товхимолоор ханган АНУ-ын өрхийн анагаах ухааны сэтгүүлийн онлайн холболт, UP TO DATE программыг ашиглуулахаар болсон. Энэхүү программ нь эмч нарт зориулагдсан олон улсын мэргэжлийн программ бөгөөд шинээр гарч буй анагаах ухааны ололт амжилт, эмчилгээ, оношлогооны дэвшилтэт технологийн талаар мэдээлэл авахаас гадна эмч нарт зайнаас суралцах боломжийг өгдгөөрөө чухал ач холбогдолтой юм.

Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор Нэгдсэн эмнэлэгт **“Сургалтын танхим”-ыг** засварлан сургалтын тоног төхөөрөмжөөр хангасан.

Нийгмийн хамгааллын чиглэлээр:

2009 онд Дүүргийн ахмад настнуудад зориулсан ээлжиндээ 28 хүн хүлээн авах чадал бүхий Сонгино дахь “Ногоон булан”-гийн амралт сувиллын үйл ажиллагаа нээн ажиллуулсанаар дүүргийн ахмад настнууд хөнгөлттэй үнээр хүссэн хугацаандаа амарч алжаалаа тайлах нөхцөлийг бүрдүүлсэн томоохон ажил болсон байна.



2011 оны 11 сарын гүйцэтгэлээс үзэхэд Нийгмийн халамжийн сангаас 6,4 тэрбум төгрөгний зарлага гаргахаар төлөвлөснөөс 93,75 хувийг буюу 6,0 тэрбум төгрөг, “Хүний хөгжил сан”-аас 35,7 тэрбум төгрөг төлөвлөснөөс 103,08 хувийг буюу 36,8 тэрбум төгрөгийг тус тус зарцуулаад байна.

тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус дүүргээс 552 ядуу өрхийг сонгон эд материалын болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлэн, амьжиргааг нь дээшлүүлж, амьдралын итгэл үнэмшил олгоход үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Дүүргийн хэмжээнд нийгмийн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,1 тэрбум төгрөг, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 900,0 сая, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,6 тэрбум, төсөл хөтөлбөрөөр 708,6 сая, бусад 271,7 сая төгрөг буюу нийт 4,6 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт ажил хийгдсэн байна.

Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Дүүргийн хэмжээнд жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгааг шинэчлэн гаргаж салбараар нь төрөлжүүлснээр нийт 168 жижиг, дунд үйлдвэрлэлд 1306 хүн, 401 өрхийн үйлдвэрлэлд 1906 хүн ажиллаж байна. Мөн

дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа 24 Хадгаламж зээлийн хоршоо, үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр ажилладаг 27 хоршоо бүртгэгдлээ.

Дүүргийн Жижиг, дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг сургалт, мэдээллээр хангах бодлогын хүрээнд “Инкубатор төв-ийн үйл ажиллагааг нээн тогтмол үйл ажиллагааг хангаж байгаа бөгөөд дүүргийн бизнесийн зөвлөлийг орон тооны бус 45 гишүүнтэйгээр байгуулан, ажиллах дүрмийг батлан Монголын Үйлдвэрлэл худалдаа, аж үйлдвэрийн тэнхим, Дүүргийн засаг дарга нарын



хооронд хамтран ажиллах “Санамж бичиг”-ийг байгуулан ажиллаж байна.

Зургаа. Байгаль орчин, тохижилт, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд Чингэлтэй дүүрэгт хийгдэж байгаа ажлын талаар:

Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд:

“Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах тухай” хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд түүхий нүүрс хязгаарлах бүсэд тус дүүргийн 7-11 дүгээр хороод, бүрэн шаталттай зуухыг нэвтрүүлэх бүсэд 12-18 дугаар хороодын айл, өрхийг хамруулсан байна.

Тохижилтын чиглэлээр:

Сүүлийн жилүүдэд Чингэлтэй дүүргийн хэмжээнд хийгдсэн бүтээн байгуулалтын ажлыг дурьдвал Бага тойруу, Анкара, Самбуу, Чоймболын гудамж, Тусгаар тогтнолын талбайн гэрэлт хөшөө, Бэгзийн Явуухулангийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн, 1, 4 дүгээр хорооны бичил цэцэрлэг, явган зам, байшин хороолол болон гэр хорооллын авто замын өргөтгөл шинэчлэлт, засвар, нийтийн эзэмшлийн болон байшин, гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх зэрэг ажлууд байна.

Үндэсний эрх чөлөөний хувьсгал ялсаны 100 жил, Ардын хувьсгалын 90 жилийн ойг тохиолдуулан “Тусгаар тогтнолын талбай”-н 2 дугаар үе шатны ажил болох цагаан боржин чулуугаар үе үеийн эрх чөлөөний төлөө тэмцэгчдэд зориулсан 19,11м өндөр “Гэрэлт хөшөө”-г босгон хөшөөний оройн мэлмийд гал,



нар, сарыг бэлэгдэж, тэдгээрийг тулж залгамжлах “Есөн хөлт цагаан туг”-аар бүслүүрдэн тугны энгэрт Соёмбо тэмдэгийг байрлуулсан байна. Дорнын их яруу найрагч Б.Явуухулангийн нэрэмжит “Цэцэрлэгт хүрээлэн”-г усан оргилуур, мини тайз, найрагчийн хүрэл хөшөө болон хамгаалалтын байр барих ажлуудыг хийж гүйцэтгэн иргэдийнхээ амьдрах таатай орчныг бүрдүүлсэн байна.



Бүгд Найрамдах Турк улсын Анкара хотын Иргэдийн хурлаас “Анкара”-гийн гудамжны нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, гудамж дагуух барилга байгууламж бүхий нийт 2,8 га талбайн тохижилтонд 700.0 мянган долларын хөрөнгө оруулалт хийхээр шийдвэрлэсний дагуу гүйцэтгэгч байгууллагаар шалгарсан Анчера, Карие ХХК-д нь тус гудамжны ногоон байгууламж, явган зам, Туркийн уламжлал болох NAZAR-г бэлэгдсэн байгууламж, усан оргилуур, амрах талбай, гэрэлтүүлэг, услалтын систем байгуулах ажлуудыг иж бүрнээр нь хийх зураг төслийн дагуу талбайг тэгшлэх, хайрга дэвсэх, бетон цутгах, гэрэлтүүлгийн шон босгох, ногоон байгууламжийн талбай бэлтгэх, хавтан тавих сандал суулгах, усан оргилуурын холболт хийх ажлууд хийгдсэн.

Нийслэл, дүүргийн өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор гудамжны тохижилтын ажлыг шинэ шатанд гаргах, чанарын шаардлага хангасан чулуун

явган зам тавих ажлыг эхлүүлэн Самбуугийн гудамжны 2 тал болон дунд талын ногоон байгууламжийн явган замын 7500 м² талбайг 20x30 харьцаатай үйлдвэрийн чулуу, 2550 м² талбайг 10x10 харьцаатай байгалийн чулуугаар шинэчлэх, 7500 м² талбайг зүлэгжүүлэх, Самбуугийн гудамжны /Зоос гоёлын уулзвараас Байгалийн түүхийн музейн уулзвар хүртэлх/ 2894 м² талбайд явган зам тавих, 668 м² талбайн ногоон байгууламжийг шинэчлэх ажлын хүрээнд Улаанбаатар банкны хойд тал, Зоос гоёл ХХК-ны уулзвараас Жайка байгууллагын өмнөх туслах зам хүртэлх 603 м² явган замын чулуун хавтан хийсэн.

Хот тохижилт, дэд бүтцийн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5,3 тэрбум төгрөг, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7,2 тэрбум, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 213,0 сая, төсөл хөтөлбөрөөр 3,1 тэрбум, Аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар 883,2 сая төгрөг буюу нийт 16,7 тэрбум төгрөгийн ажил хийгдсэн.

Чингэлтэй дүүргийн үе үеийн Засаг дарга нар.....

Чингэлтэй дүүргийн Засаг даргаар 1992-1996 онд А.Зул, 1996-2000 онд С.Нармандах, 2000-2004 оны 8дугаар сарын 5-ныг хүртэл М.Амарсайхан, 2004-2008 оны 7 дугаар сарын 15-ныг хүртэл Д.Очирбат, 2008 оны 9 дүгээр сарын 15-наас 2008 оны 12 дугаар сарын 20-ныг хүртэл Х.Батбилэг, 2008 оны 12 дугаар сарын 20-ноос 2012 оны 10 сарын 01 –ны өдөр хүртэл Д.Ганболд , 2012 оны 10 дугаар сарын 10 ны өдрөөс Т.Аюурсайхан нар томилогдон ажиллаж байна.

Дүүргийн дотоод, гадаад хамтын ажиллагаа...

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар нь 1997 оноос Булган, Баянхонгор, Өвөрхангай аймгуудтай, 2001 оноос БНХАУ-ын Хөх хотын Сайхан дүүрэг, БНСУ-ын Сөүл хотын Сунгпа дүүрэг, ОХУ-ын Зелёноград хотуудтай найрсаг хамтын ажиллагаа тогтоон эрүүл мэнд, боловсрол, нийгмийн салбар, төр захиргааны байгууллагын чадавхийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна.

Чингэлтэй дүүргийн Засаг дарга болон түүний Тамгын газар нь 2012 оны байдлаар:

А/Засаг даргын Тамгын газар нь:

- 1/ Төрийн захиргааны хэлтэс
- 2/ Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс
- 3/ Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс
- 4/ Нийгмийн хэлтэс
- 5/ Цэргийн штаб
- 6/ Аж ахуйн тасаг

Б: /Засаг даргын дэргэдэх хэлтэс албад

- 1.Татварын хэлтэс
- 2.Нийгмийн даатгалын хэлтэс
- 3.Цагдаагийн хэлтэс
- 4.Замын цагдаагийн тасаг
5. Халамж үйлчилгээний хэлтэс
- 6.Эрүүл мэндийн нэгдэл
- 8.Биеийн тамир спортын хороо
- 9.Статистикийн хэлтэс
- 10.Газрын алба
- 11.Мал эмнэлэг үржлийн алба
- 12.Тохижилт үйлчилгээний компани
13. Иргэний бүртгэлийн хэлтэс
14. Онцгой байдлын хэлтэс гэсэн бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Хоёр. ХӨМРӨГИЙН БАРИМТЫН ТҮҮХ

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн шууд удирдлагын дор Архивын эрхлэгч, Бичиг хэргийн эрхлэгч нар зохион байгуулан ажилладаг.

Нийслэлийн Засаг даргын 1992 оны Б/212 дугаар захирамжаар батлагдсан орон тоо, цалингийн фондыг үндэслэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн орон тоонд ажиллах хүмүүсийг дүүргийн Засаг даргын 1992 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 04 тоот захирамжаар батлагдсаны дотор даргын нарийн бичиг, бичиг хэргийн эрхлэгч Г.Цэрэндолгор, бичээч Ө.Наранцэцэг, В.Пүрэвжаргал нарыг томилсон байна. 1996-7-р сард Г.Цэрэндолгор өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж, Цэцэгмаа 1996-7-сараас томилогдон ажиллаж байгаад 1998 онд өөр газар шилжсэн тул 1999-4-8-ны өдрийн 78 тоот захирамжаар архив, бичиг хэргийн эрхлэгчээр Я.Алтанцэцэг, 2005 онд Д.Батчимэг, 2008-2009 онд Н.Энхжаргал, Ш.Отгонтуяа, Т.Дарамсүрэн, 2010 оноос Д.Батчимэг, 2011 оны 11 сараас бичиг хэргийн эрхлэгчээр Ү. Мөнхцэцэг, 2011 оны 05 сараас Л.Баттогтох архивын эрхлэгчээр тус тус ажиллаж байна.

Дүүргийн Засаг даргын 2009 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 58 дугаар захирамжаар Тамгын газрын архивын дүрэмийг хавсралтаар шинэчлэн баталж, архивын баримт бичиг нягтлан шалгах комиссыг дараахи бүрэлдэхүүнтэй байгуулав.

Комиссын дарга	Ц.Алтанцацрал	Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга	Д.Батчимэг	Архив бичиг хэргийн эрхлэгч
Гишүүд	Ж.Эрдэнэбат Л.Ариунзаяа С.Оюун-эрдэнэ	Санхүү эдийн засаг төрийн сангийн хэлтсийн дарга Эрхзүйн мэргэжилтэн Иргэний бүртгэлийн тасгийн дарга

БНШК нь ажиллах хугацаандаа задгай байсан олон баримтыг цэгцэлж байнга хадгалах баримтын данс, түр хадгалах баримтын бүртгэл, устгах баримтын жагсаалт зэргийг үйлдэж, Тамгын газрын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хэлэлцэх, архивын баримтын тооллого явуулах, архивын улсын үзлэгт бэлтгэх болон архивын талаар цаг үеийн холбогдолтой асуудлуудыг хэлэлцэж баталж ажилласан.

1993 оноос архивт баримт бүрдүүлж авч эхэлсэн бөгөөд 1997 он хүртэлх баримт дутуу хагас байсан ба 1999 оноос бүрэн бүрдэлтэй болсон.

Чингэлтэй дүүрэг нь УИХ-ын 1992 оны 08 сарын 18-ны 18 дугаар тогтоолоор шинээр зохион байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойшхи удирдлагын цаасан суурьтай 1992-2001 оны байнга хадгалах 192 хадгаламжийн нэгжээр анх удаа 2002 онд “Архивын тухай хууль”-ийн 23 дугаар зүйлд заасанхуулийн хугацаанд Нийслэлийн Архивын газрын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлж байжээ.

Энэ ажлын хүрээнд 2002 оны 4 дүгээр сарын 17-ноос 5 дугаар сарын 13-ны хооронд Нийслэлийн архивын албатай гэрээ байгуулан ЭШТБ-ын ажлыг ахлах архивч Д.Жаргалсүрэн, 1994, 1997, 2000, 2001 оны 6 хадгаламжийн нэгж, архивч Ч.Цэцэгмаа 1993, 1996, 1999, 2001 оны ИТХ-ын баримт, жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, хороодын баримт, У.Золзаяа 1992, 1995, 1998, 2001 оны жилийн төлөвлөгөө тайлан, хороодын баримтыг эмхэлж цэгцэлсэн байна.

ЭШТБ-ын ажлыг “Байгууллагын архивын заавар”, БНМАУ-ын Улс олон нийт, хорооллын байгууллагын баримт бичиг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтын дагуу хийж гүйцэтгэсэн. Үүнд: бүлэглэж, ач холбогдолоор нь буюу он цаг, зохион байгуулалтын дараалалд оруулж, 1992-2002 оны 192 ширхэг байнга хадгалах хадгаламжийн нэгжийн данс, 1993-2002 оны 85 ширхэг 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, 1993-2002 оны 432 ширхэг түр хадгалах

хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгалын 169 ширхэг хадгаламжийн нэгж, 22.3 кг баримтанд түүвэр жагсаалт үйлдсэн.

Мөн 2002-2006 оны 436 ширхэг, 2006-2007 оны 47 ширхэг, 2007-2008 оны 45 ширхэг байнга хадгалах хадгаламжийн нэгжийн үргэлжлэх данс, 2002-2006 оны 150 ширхэг 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн үргэлжлэх бүртгэл, 2006-2007 оны 127 ширхэг, 2007-2008 оны 29 ширхэг 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн үргэлжлэх бүртгэл, 2002-2006 оны 685 ширхэг, 2006-2007 оны 299 ширхэг, 2007-2008 оны 49 ширхэг түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл үйлдэж данс, бүртгэлийг батлуулан хүлээлгэж өгсөн байна.

Архивын хадгаламжийн нэгжүүдийг зориулалтын хавтсаар бүрэн хавтаслан, баримтын нэр төрөл, ач холбогдолоор нь дараалуулан он оноор нь байрлуулан заагч хийж, тавиурын заагуурыг зааврын дагуу хийсэн байна.

2000, 2004, 2009 оны архивын улсын үзлэгээр тус тус хангалттай гэсэн үнэлгээ авч, 2009 онд Байгууллагын архивын гэрчилгээ авсан.

Монгол Улсын “Архивын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалт, “Нийслэлийн эдийн засаг нийгмийн 2011 оны зорилт”-ыг тус тус үндэслэн гарсан Нийслэлийн Засаг даргын 2011 оны 250 дугаар захирамж, Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2011 оны А/80 дугаар захирамж, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2011 оны А/80 дугаар тушаалуудын хэрэгжилтийг хангуулах үүднээс Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газарт хадгалагдаж байгаа архивын баримтын тоо хэмжээг тодорхойлох, хадгалалт, хамгаалалтын нөхцөл бололцоо, боловсон хүчний нөөц, тэдгээрийн мэргэшлийн байдал зэргийг тодорхойлсон нэгдсэн тооллогыг зохион байгуулан явуулсан бөгөөд батлагдсан удирдамж чиглэлийг мөрдлөг болгон Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газарт хадгалагдаж байгаа удирдлагын, үндсэн үйл ажиллагааны цаасан суурьтай болон тусгай төрлийн баримтыг тооллогод бүрэн хамруулсан бөгөөд баримтуудыг бүртгэл, жагсаалттай нарийвчлан тулгаж тооллого явуулсан.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын цаасан суурьтай баримтын талаар:

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын архив нь үйл ажиллагаандаа 2007 оны Үндэсний Архивын газрын даргын баталсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар” /цаашид заавар гэх/ болон

холбогдох эрхзүйн актуудыг мөрдлөг болгон ажилладаг ба архивын нөхөн бүрдүүлэлтийн эх үүсвэр нь зааврын 3.1.2-т заасны дагуу зохион байгуулалтын үндсэн нэгжүүд буюу төрийн захиргааны удирдлагын хэлтэс, санхүү, төрийн сангийн хэлтэс, үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс, нийгмийн хэлтэс, аж ахуйн тасаг, иргэний бүртгэлийн тасгуудын удирдлагын болон үндсэн үйл ажиллагааны чиглэлээр тухайн онд үүссэн бүх төрлийн баримтууд болно.

Тамгын газрын архив нь зааврын 3.2.1-т заасны дагуу дээрх үндсэн хэлтэс нэгжүүдээс батлагдсан төлөвлөгөө хуваарийн дагуу Үндэсний Архивын газрын даргын 2008 онд баталсан “Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт”-ыг удирдлага болгон байнга, түр хадгалах хадгаламжийн нэгжүүдэд техник боловсруулалт хийж, бүртгэлийн дагуу хүлээн авдаг бөгөөд 2013 оны эхний хагас жилийн байдлаар 1993-2012 оны 5300 цаасан суурьтай баримт хадгалагдаж байна.

Тамгын газрын архивт хадгалагдаж байгаа баримтуудыг нэр төрөл, асуудал сэдвээр ангилж үзвэл Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаал, Засаг даргын мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтууд, тогтоол шийдвэр, тэдгээрийн биелэлт, Тамгын газрын жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, жилийн эцсийн тайлан, тэнцэл, Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, хороодын Засаг даргын захирамж, хүн амын тооллогын баримт бичиг, харилцсан бичиг, үр дүнгийн гэрээ, биелэлт, касс, харилцахын баримт, аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудын улирал, жилийн эцсийн санхүүгийн баримтаас тус тус бүрдэж байна.

Дээрх удирдлагын цаасан суурьтай баримтын эрдэм шинжилгээ техник боловсруулалтын байдалд дүн шинжилгээ хийн зохион байгуулалтын нэгж ажилтнуудын тухайн жилд боловсруулсан үндсэн үйл ажиллагааны холбогдолтой баримт бичигтэй ажиллах, тэдгээр баримтаар хэрэг бүрдүүлэх, хадгалах хугацаа, нэр төрлөөр нь ангилан цэгцлэх зэрэг ажиллагаа архивын холбогдох заавар, журмын шаардлагад нийцүүлэхээр ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд санхүүгийн баримт, тайлан тэнцэл, захирамж, захирамжийн биелэлт, зохион байгуулсан ажлын тайлан, мэдээ зэрэг баримтуудыг хадгалах хугацааны жагсаалтад дурьдсаны дагуу жилийн эцэс, улирал, сараар болон хэргийн бүрдлээр нь ангилан төрөлжүүлсэн, байнга хадгалах баримт бичгийн хуудас 250 -д тааруулан дахин үдэж хавтасласан, хуудсыг зааврын дагуу дугаарласан, олон

асуудал сэдэвт хамаарах тус тусдаа хэрэг бүрдүүлэх баримтуудыг салгаж, тусдаа хадгаламжийн нэгж болгосон, хадгаламжийн нэгж дотор баримтыг он цаг, ач холбогдлоор нь дараалаагүй, шаардлагатай баримт бичигт дотоод товъёог үйлдсэн зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тусгай төрлийн баримтын талаар:

Дүүргийн Засаг даргын тамгын газрын архивт 2 ширхэг кино хальс болон 15 ширхэг DVD хальс эх хувиараа хадгалагдаж байгаа бөгөөд эдгээр баримтууд нь он цагийн хувьд 2002-2012 оныг хамарч байна. Тухайн баримтад дүүргийн тамгын газрын жилийн ажлын төлөвлөгөө, биелэлт болон тэмдэглэлт ойн үеэр буулгасан дүрс бичлэгийн баримт, 2009-2012 оны засаг даргын мөрийн хөтөлбөрийн кино танилцуулга зэрэг бичигдэн архивт хадгалагджээ. Дүүргийн хэмжээнд гэрэл зургийн баримтаар цомог үүсгэж байгаагүй бөгөөд дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны явцад үүссэн олон асуудал сэдэв, үйл явдалд хамаарах цөөн тооны буюу 125 позитив хальс бүртгэлгүй хадгалагдаж байсныг альбомжуулан нэгж үүсгэсэн байна.

Мөн Засаг даргын Тамгын газрын архивт холбогдох хэлтэсүүдээс хүлээн авсан барилгын зураг төслийн 1991-2012 оны 43 хадгаламжийн нэгжийг нягтлан шалгаж үдэж хавтаслан зураг төслийн баримтын байнга хадгалах бүртгэл үйлдэж байгууллагын архивт хадгалахаар тавиурт өрж байрлуулсан.

Засаг даргын Тамгын газрын үндсэн хэлтсүүдээс нөхөн бүрдүүлэлтээр баримт авахдаа тухайн он болон үндсэн үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан түүхэн, тэмдэглэлт үйл явдлын гэрэл зураг, дүрс бичлэгийг тухайн асуудал сэдэвт хамаарах чиглэлийн дагуу ангилан төрөлжүүлж, цомгийн болон позитив хэлбэрээр, мөн тусгай тээгчид /CD, DVD/ буулган цаасан суурьтай баримтын адилаар архивт тогтмол хүлээн авч хэвшүүлэх ажлыг хийж байна.

Цаасан баримтыг цахим хэлбэрт оруулах, тэдгээрт ашиглалтын болон хадгалалтын хувь үйлдэх ажлын хүрээнд 2002-2012 оны дүүргийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал байнга, 70 жил хадгалах 55 хадгаламжийн нэгжийн 4897 баримтыг архивын AMS программд шивж оруулан он тус бүрээр DVD-д буулгаж 11 цахим хадгаламжийн нэгж үүсгэн бүртгэлийг үйлдэн

1 хувийг Нийслэлийн Архивын газарт шилжүүлж, 1 хувийг Засаг даргын Тамгын газрын архивын сан хөмрөгт авсан байна.

Мөн Засаг даргын Тамгын газрын архивын 70 жил хадгалах баримтанд хадгалагдаж байсан цагаатгалын нөхөн олговор олгосон тухай санхүүгийн баримт бичгийг хөмрөгийн хамаарлын дагуу 1998-2011 оны 24 хадгаламжийн нэгж, мөн хороодын Иргэдийн Нийтийн хурлын тогтоол, холбогдох баримт бичгээс бүрдсэн 2008-2012 оны 5 хадгаламжийн нэгжид тус тус бүртгэл үйлдэн хөмрөгийн хамаарлын дагуу дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгсөн болно.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас архивын үйл ажиллагаанд төлөвлөж байгаа ажлын нэг нь байгууллагын архивын сан хөмрөгөөс “Хосгүй үнэт”, “Нэн үнэт” баримтуудыг зохих төрийн архивын мэргэжил аргагүйн зөвлөгөө, удирдлагын хүрээнд нээн илрүүлэх, шаардлагын түвшинд хүргэх, мөн дүүргийн Засаг даргын Тамгын газарт болон дүүргийн харъяалалтай, дүүрэгт ажиллаж, амьдарч байгаа төр, нийгэм, соёл, шинжлэх ухаан, урлаг, спорт болон нийгмийн амьдралын бусад салбарт оруулсан хувь нэмэр, гүйцэтгэсэн үүрэг, ач холбогдол зэрэг байдлыг харгалзан үзэж, байгууллагын архивыг хувийн гаралтай баримтаар нөхөн бүрдүүлэх үйл ажиллагаа бөгөөд энэ ажилд дүүргийн удирдлагын зүгээс тодорхой анхаарал хандуулан ажиллаж байна.

Архивын байр, хадгалалтын хэрэгслэлийн талаар:

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас байгууллагын архивын баримтын бүрэн бүтэн байдлыг хангах чиглэлээр хадгалалтын материаллаг суурь бий болгох асуудлыг үе шаттай төлөвлөн хэрэгжүүлж байгаа ба 2009 онд байгууллагын архивын өрөөг орчин үеийн шаардлагад нийцсэн нягтруулсан шүүгээ, зориулалтын баримт зөөх шат, тэргэнцэр, галын болон хамгаалалтын дохиоллын систем, чийг дулаан хэмжигч багаж, баримтанд эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийхэд шаардагдах туслах багаж хэрэгсэл зэргээр бүрэн хангаж өөрчлөн тохижуулсан бөгөөд одоогийн дүүргийн Засаг даргын Тамгын газар нь архивын баримтыг байгууллагын өөрийн байранд 30 м,кв өрөө бүхий, хадгалалтын ерөнхий шаардлагыг хангасан, багтаамжийн байдал хэвийн, 154 нүд 15,6 м тавцангийн урттай 6 ширхэг шүүгээнд хадгалж байна.

Байгууллагын архивын ажлын үндсэн зааврын 4.6.4 –д заасныг үндэслэн хадгаламжийн сангийн өрөөнд жилд 1-2 удаа мэргэжлийн байгууллагаар шавьж устгалын хор цацуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлдэг. Архивын баримтыг байгууллагын даргын зөвшөөрлөөр ашиглуулж байгууллага иргэдэд лавлагаа олгох журмыг 2011 онд боловсруулан батлуулсан байна.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын архивын баримтанд ЭШТБ хийсний үр дүнд байнга хадгалах 427 ХН баримтыг үдэж хавтаслан, хуудас дугаарлан, шаардлагатай нэгжид сэлбэн засалт хийж, данс нэгтгэн бүртгэл үйлдэж, ББНШАЗК-ын 03 дугаар хурлаар хэлэлцүүлэн батлуулсан байна.

Баримтыг цэгцлэх явцад:

- 2007-2012 оны дүүргийн Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаалыг үйл ажиллагааны чиглэл, боловсон хүчний чиглэлээр ангилан ялгаж байнга болон 70 жил хадгалахаар бүртгэлд авав.
- Дээрх байнга хадгалах хадгаламжийн нэгжээс бүх баримтыг задлан дахин боловсруулалт хийсний үр дүнд 2002-2012 оны 438 хадгаламжийн нэгжид ЭШТБ, дахин боловсруулалтын ажлыг хийж данс, бүртгэлийг үйлдсэн.
- Түр хадгалах 2002-2012 оны нийт 1988 хадгаламжийн нэгжийг он зохион байгуулалт, нэр төрлөөр ангилан ялгаж хадгаламжийн нэгжийн дугаар өгч бүртгэл үйлдэн задгай болон хавтас солих шаардлагатай баримтыг сольж, эмхлэн цэгцэлж, тавиурт байрлуулсан болно.
- Түр хадгалах баримтанд 1992-2000 оны багцалсан нэг санхүүгийн тайлан баланс байсныг задлан он тус бүрээр хэрэг бүрдүүлсэн бөгөөд Нийслэлийн Архивын газарт шилжүүлсэн 2002 оноос өмнөх баримтын бүртгэлд хамаарах 1992-2001 оны Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлан баланс, орон нутгийн болон улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан, Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл /гар бичмэл/ зэрэг 23 хадгаламжийн нэгжид тусдаа бүртгэл үйлдэн Нийслэлийн Архивын газарт хадгалагдаж байгаа өмнөх данс бүртгэлд оруулахаар хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн.
- Чингэлтэй дүүргийн харьяа аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг ҮЖ-126 в заалтыг үндэслэн 2002- 2008 оны 615 хадгаламжийн нэгжийг 5 жил хадгалахаар устгахаар ялгасан болно.
- Мөн архивт хадгалагдаж байсан Засаг даргын Тамгын газрын 1997-2002 санхүүгийн буюу кассын баримтыг задлан байнга хадгалах болон 70 жил

хадгалах баримтыг ялган авч, үлдэх баримтанд устгах хэргийн акт үйлдсэн. Харин 2003 оноос хойшхи баримтын хадгалах хугацаа дуусаагүй учир задлаагүй, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлд оруулсан.

- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан 1995-2012 оны хадгаламжийн нэгжид мөн дахин боловсруулалт хийж тооцооны хуудсыг 70 жил хадгалах баримтанд, шимтгэл төлөлтийн 07 маягтын дагуу гаргасан тайланг байнга хадгалах баримтанд авч данс, бүртгэлд оруулсан.
- Засаг даргын Тамгын газрын архивын 70 жил хадгалах 1992-2012 оны 78 хадгаламжийн нэгж болох цалингийн карт, цалингийн тооцооны хүснэгт, төрийн дээд одон медаль олгохтой холбоотой баримт, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооны хуудас, 2007-2012 оны боловсон хүчний холбогдолтой Захирамж, тушаал, асран хамгаалагч тогтоолгохтой холбогдох баримт, Засаг даргын Тамгын газрын хэлтэс, хороод, дэргэдэх хэлтэс албадын ажилтан, албан хаагчдаас орон сууц хүссэн өргөдөл, ахмад настнуудад гэр олгосон тухай баримт зэрэг нийт 78 хадгаламжийн нэгжид дахин боловсруулалт хийн бүртгэл үйлдэн байгууллагын архивт хадгалахаар тавиурт өрж байрлуулсан.
- Хадгалах хугацаа дууссан, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн баримтад устгах хэргийн акт үйлдсэн.
- Дээрх ажлын үр дүнд нийслэлийн Архивын газарт 50 дугаар хөмрөгт байнга хадгалах 2002- 2012 оны 427 хадгаламжийн нэгж бүхий данс үйлдэв. Мөн түр хадгалах 2002-2012 оны 1988 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 1992-2012 оны 78 хадгаламжийн нэгж, устгах хэргийн 1997-2008 оны 19 хэргийн 762 хадгаламжийн нэгжийг устгахаар акт үйлдэв.

Гурав. ХӨМРӨГИЙН БАРИМТЫН ТОДОРХОЙЛОЛТ

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын архивт 2002- 2012 оны 427 хадгаламжийн нэгж бүхий данс үйлдэв. Мөн түр хадгалах 2002-2012 оны 1988 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 1992-2012 оны 78 хадгаламжийн нэгж тус тус хадгалагдаж байна.

1992-2002 оны байнга хадгалах дансанд Засаг даргын захирамж, Тамгын газрын жилийн ажлын ажлын төлөвлөгөө, тайлан, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт, Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлын тэмдэглэл, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал, Хүн амын жилийн эцсийн тооллогын бүртгэл, хороодын засаг даргын захирамж зэрэг баримтуудаас бүрдэж байна.

Тамгын газрын архивт хадгалагдаж байгаа баримтуудыг нэр төрөл, асуудал сэдвээр ангилж үзвэл Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаал, Засаг даргын мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтууд, тогтоол шийдвэр, тэдгээрийн биелэлт, Тамгын газрын жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, жилийн эцсийн тайлан, тэнцэл, Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, хороодын Засаг даргын захирамж, хүн амын тооллогын баримт бичиг, харилцсан бичиг, үр дүнгийн гэрээ, биелэлт, касс, харилцахын баримт, аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудын улирал, жилийн эцсийн санхүүгийн баримтаас тус тус бүрдэж байна.

Хөмрөгийн 70 жил хадгалах бүртгэлд Иргэний бүртгэлийн баримтууд үүнд /овог, нэр, нэр солилт, төрөлт, гэрлэлт бүртгэлт, цуцлалт, үрчлэлт, эцэг тогтоолт, иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэлүүд/, Тамгын газрын 70 жил хадгалах баримтанд 1992-2011 онд хамаарах цагаатгалын нөхөн олговрын баримт, цалингийн цэс, карт, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тухай тайлан, Төрийн дээд одон медальд тодорхойлогдсон хүмүүсийн хуралдааны тэмдэглэл, тогтоол, холбогдох баримт бичиг, Асран хамгаалагч харгалзан дэмжигч тогтоох тухай холбогдох баримт бичиг, Чингэлтэй дүүргийн Засаг даргын боловсон хүчний чиглэлээр гарсан захирамж, Тамгын газрын даргын тушаал зэрэг баримтууд байна.

1992-2001 оны дансыг Нийслэлийн архивын албаны ахлах архивч Д.Жаргалсүрэн, архивч Ч.Цэцэгмаа, У.Золзаяа нар, 2002-2011 оны бүртгэлүүдийг Архивын эрхлэгч Л.Баттогтох нар хийж гүйцэтгэсэн байна.

Байгууллагын архивын сан хөмрөгийн баримтыг мэдээлэл, лавлагааны зорилгоор байгууллага иргэдэд ашиглуулахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулах үүднээс 2011 онд “Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас архивын баримт ашиглуулах журам”-ыг боловсруулан гаргаж батлуулсан.

Чингэлтэй дүүргийн хамгийн анхны түүхчилсэн лавлахыг дүүргийн ИТХ-ын даргаар ажиллаж байсан Дамбадаржаагийн Тогтохжаргал бичиж, товхимолоор үлдээсэн байдаг байна.

2012 онд архивын эрхлэгч Л.Баттогтох нь өмнөх баримтуудад тулгуурлан сийрүүлэн, баяжилтийг хийж бичсэн болно.